

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.08.30, ЛИХАГВА ~ №163 (709)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Оросын Төрийн тэргүүнтэй уулзлаа.
УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурал хойшиллоо.
АТГ-ын орон тооны бус зөвлөлийг Ахмадын чөлөөт холбооны тэргүүн Г.Баасан удирдана.
Монгол, АНУ, Японы ГХЯ-д хоорондын гурван талт уулзалт өнөөдөр болно.
Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хурлаар засгийн асуудлыг хэлэлцэнэ.

ЭДИЙН ЗАСАГ

ММС-гийн орлого оны эхний хагаст найм дахин өсөж, 245.9 сая ам.долларт хүрэв.
"Сүү" компани нийт 3.44 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараана.
Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн мэдээллийг ТҮЦ машинаас авах боломжтой.
"Sinopac" компанийн эхний хагас жилийн ашиг 40 хувиар өсчээ.
ОХУ-ын улаанбуудайн экспортын ханш дөрвөн долоо хоног дараалан буурав.

НИЙГЭМ

Хан-Уулын хорио тогтоосон бүсийн сургууль, цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулна.
Автомашин захиуудыг хотын төвөөс гаргаж эхэллээ.
Нийслэлийн 51 сургуульд 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр засвар хийжээ.
Техникийн доголдолтой, өнгө үзэмжгүй автомашиныг хил хооронд явуулахгүй.
Баянзүрхчүүд Туул гол орчмын есөн тонн хог хаягдлыг цэвэрлэв.

ДЭЛХИЙ

Пхеньян пуужин харвасантай холбогдуулан НҮБ-ын Аюулгүйн зөвлөл хуралдана.
ХБНГУ дахь цагаачид 2016 онд 4.2 тэрбум еврог эх орондоо гуйвуулжээ.
АНУ В61-12 атомын бөмбөгийг цөмийн цэнэггүйгээр туршив.
Японы хоолны газрууд тамхи татдаг хэсэгт үйлчлүүлэгчдээ нэмэлт төлбөр авна.
Хүнд нойр дутвал согтуурахаас илүү уршигтайг эрдэмтэд нотоллоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.08.30



15° 1°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРИЙН МЭДЭЭЛИЙГ 8 ДУЛААР НУУРГУУС ҮНШИНЭ ҮҮ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Амь сөрсөн хөдөлмөр



Улаанбаатарын нэг шөнө эх орныхоо төлөө дайтах бус архины халуунд хөлчүүрхэж, хүний амь бүрэлгэхээс ч буцахгүй явдлуудаар бужигнана. ▶7

С.Батсайхан / ЗГМ ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Босго нь намдсан Монголын төр

Б.Даваатогтох @datoZGM

"Өглөө орноосоо эртхэн босож чаддаггүй залуус УИХ-ын гишүүн болчихоод, улс орныг хойш нь чирээд байна. 40 хүрээгүй, гэсвэл дөнгөж өнгөрч яваа гишүүдийн хийж байгаа үйлдэл, хэлж байгаа үг, яриаг анзаараад үзээрэй. Зүгээр л гал халуун хүсэл, зоригоос цаашлахгүй. Ядаж байхад, сүүлийн үед баян, эрх мэдэлтэй хүмүүсийн хүүхдүүд автоматаар улс төрд орж ирдэг болчихсон. Гэр хорооллын гудамжаар алхаж ч үзээгүй, гал яаж түлдэг ойлголтгүй шахам нөхдүүд ард түмэн гэж худлаа орилж, саарал ордонд сууж байна. Ийм байхад улс орон өөдөлж, дэвжиж, иргэдийн зовлон нимгэрч, жаргах уу. Мөн өндөр албан тушаалд очсон залуус улсын ажил хийхээсээ илүүтэй хоцорсон, тасалснаараа хошуучилж, элдэв хүүхэнтэй нэр холбогдож, эд хөрөнгө хураахын дон тусаж байна" хэмээн УИХ-ын нэгэн дэд дарга чуулганы хуралдааны үеэр залуу парламентчдад хандан хатуу боловч үнэн үгийг дайж байсан нь саяхан. Гучин насны босго ч алхаагүй байхдаа саарал ордны буурал "бурхи"-нуудтай тохой нийлүүлэн суусанд нь атаархсандаа бус, харин анхаарах ёстой асуудал хөндөгдсөн учир үнэтэй үгээ харамгүй хэлсэн болов уу.

▶3

ЗГМ: ИНФОГРАФИК



НИЙГЭМ

Тооцоолоогүй шийдвэрийн уршиг

З.Цэлмэг @tselmegZGM

Хүнээр зүйрлэвэл, цусны даралт нь ихсэж хэзээ мөдгүй харвах дөхсөн болов уу гэмээр их ачаалал нийслэлийн авто замын "судас"-ыг лугшуулж байна. Гол судсыг эс тооцвол бусад хэсгийн цусны эргэлт бараг л зогсчээ. Хичээлийн шинэ жилийг угтан хот руу чиглэдэг их нүүдэлтэй зэрэгцэн шийдвэрлэсэн авто замын хөдөлгөөний шинэ зохицуулалт нийслэлийнхнийг бараг л царцаачихаад байна. Хэрэгжиж эхлээд 14 хонож буй уг шийдвэрийн уршгаар

нэг жолоочийн автомашиндаа өнгөрүүлэх хугацаа, зарцуулах түлш нэмэгдэж, хувь хүмүүс эдийн засгаараа чамгүй хохирч буй.

Мэргэжлийн байгууллагаас гаргасан судалгаагаар, шинэ зохицуулалтын дагуу замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарын нэг өдөрт туулах зай дунджаар 1.2 км-ээр нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлтэд эдийн засгийн багахан тооцоо хийхэд бэлтгэл, судалгаа дулимаг болсон эл шийдвэрийн хор уршиг арилгах аргагүй их гэдэг нь ойлгогдоно.

▶5



Умард Солонгосын пуужинд Япон түгшүүр зарлав

Катрина Мэнсон

Японы Засгийн газар тус улсын хоёр дахь том арал Хоккайдогийн оршин суугчдыг хоргодог газарт байрлуулах түгшүүр зарласан нь байдал хурцадсаны илрэл боллоо. Умард Солонгос орон нутгийн 05.58 цагт пуужин харвасан тухай Японы Засгийн газрын кабинетийн нарийн бичгийн дарга Ёшихидэ Сүга мэдэгдэв. Пуужин 06.06 цагт Хоккайдо арлын дээгүүр өнгөрч, Японы эргээс дорно зүгт 1180 километрийн зайд Номхон далайд унасан байна.

Тус улсын зэвсэгт хүчин пуужинг онож, устгах оролдлого хийсэнгүй. Японы Засгийн газар Үндэсний аюулгүй байдлын

зөвлөлөө яаралтай хуралдуулж, далайд унасан пуужингийн үлдэгдлээс хохирол учирсан эсэхийг тодорхойлохоор хичээж буйг ноён Сүга хэвлэлийн хурлын үеэр мэдэгдэв.

"Манай улсын аюулгүй байдалд урьд өмнө тохиолдож байгаагүйгээр заналхийлсэн хэрэг. Цаашилбал, Ази-Номхон далайн бүс нутгийн тогтвортой байдалд заналхийллээ" хэмээн ноён Сүга өгүүлж байна.

Пуужин харвасан мэдээллийг Пентагон мөн батлав. "Умард Солонгосоос харвасан пуужин Японы дээгүүр нисэж өнгөрсөн нь үнэн.

▶9

Table with 7 columns: MSE ALL (952.48, 0.24%), АЛТ (1319.20, 0.74%), ЗЭС (6666, 0.33%), 10-ЧИНГИС БОНД (96.980, 0.07%), 5-ЧИНГИС БОНД (100.40, 0.00%), АМ.ДОЛЛАР (2433.65), ЮАНЬ (368.75), РУБЛЬ (41.54)

Улс төр

БҮЛЭГ

Хаалттай хурал ширүүн уур амьсгалд өрнөв

Гарын үсэг зурсан зарим гишүүн байр сууриасаа буцаагүй

Б.Бямбасүрэн
@byambaZGM

УИХ дахь МАН-ын бүлгийн нэр бүхий 30 гишүүн Засгийн газрыг огцруулахаар гарын үсэг зурж, УИХ-д өргөн бариад буй. Уг асуудлыг хэлэлцэх МАН-ын бүлгийн хаалттай хуралдаан өчигдөр Төрийн ордонд болов. Хаалттай хуралд 65 гишүүнээс 48 нь ирсэн юм. Хуралд УИХ-ын дарга М.Энхболд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Шадар сайд У.Хүрэлсүх, МАН-ын генсек Д.Амарбаясгалан болон УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа нар оролцлоо.

Үдээс хойш эхэлсэн бүлгийн хуралдаан нэлээд ширүүн уур амьсгал дунд өрнөж, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг огцруулах, эсэхэд гишүүд байр сууриа илэрхийлжээ. Түүнчлэн огцруулах бичигт гарын үсэг зурсан гишүүд байр сууриасаа буцсан гэх мэдээлэл гарсан юм. Энэ талаар УИХ-ын гишүүн Ж.Ганбаатарас тодруулахад “Гарын үсгээсээ буцсан хүн байхгүй. Би Засгийн газраас тендер авч, төртэй холбоотой ажил хийж үзээгүй. Хувийн ямар нэгэн ашиг сонирхол байхгүй. Гарын үсэг зурсан 30 гишүүн ч байр сууриа хатуу хадгална гэдэгт найдаж байна” гэв. Хурлын дундуур Засгийн газрыг огцруулах саналд гарын үсэг зурсан УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир байр сууриасаа буцаагүй гэдгээ мөн баталсан юм. Тэрбээр “УИХ-ын гишүүд гарын үсэг зурчихаад маргааш нь болилоо гэдэг хариуцлагагүй, замбараагүй үйлдэл гаргахгүй.



Б.Ганбаяр / ЗГМ ©

Бид хэн нэгний шахалтад орохгүй. Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд хариуцлага тооцох асуудлыг хөндөж, хоёр ч сонгууль дамнан яригдсан 60 тэрбум төгрөгийн хэрэгт шүүмжлэлтэй хандсан. Бид намынхаа ирээдүйг бодож, асуудалд итгэл үнэмшлээрээ хандсан” гэв.

Түүнчлэн МАН хагарч, бутардаг улс төрийн хүчин биш. Асуудлыг догроо эвтэй шийддэг. Хамгийн гол нь, Монгол төрийн ажил гацаж болохгүй, тасралтгүй явах учиртай. Бүлгийн хурлаар Засгийн газар болон нийслэлийн үйл ажиллагаатай холбоотой шүүмжлэл ихээхэн гарч байна гэж УИХ-ын гишүүн Д.Сумъяабазар нэмж хэллээ.

Хаалттай хуралдааны “цаг агаар” тааруу байгааг гишүүд дурдаж байлаа. Учир нь хуралд оролцсон бүх гишүүн өөрсдийн

байр сууриас асуудалд хандаж, хүн бүрээс янз бүрийн санал гарч байгааг нуугаагүй юм. Хамгийн чухал нь, хурлаас зөв шийдэл, гарц олохыг чухалчилж буйгаа гишүүд онцоллоо. Хурал хаалттай явагдсан учир гишүүдийн зүгээс үүнээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй байлаа.

УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж гарын үсгийн тоог нэгээр нэмэв

Дугаар шилжих мөчид МАН-ын бүлгийн хурал үргэлжилж байсан бөгөөд УИХ-ын дэд

дарга Ц.Нямдорж Засгийн газрыг огцруулах бичигт гарын үсэг зурсан мэдээллийг өглөө. Ингэснээр Засгийн газрыг огцруулахаар МАН-ын 31 гишүүн санал нэгджээ. Засгийн газрыг огцруулах, эсэх асуудлыг өнөөдөр үргэлжлүүлэн хэлэлцэх бөгөөд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар бүлгийн санал дүгнэлтийг хэлэлцэх юм.

Дашрамд дурдахад, Ерөнхий сайд анх томилгоосон цагаасаа Монгол Улсын хууль тогтоомжийг зөрсөн, ард түмний эрх ашигт нийцээгүй, цөөн хэдэн бүлэглэлийг дэмжсэн шийдвэрүүд гаргасан хэмээн огцруулах бичиг өргөн барьсан. Мөн зарим гаргасан шийдвэрээсээ эргэж буцсан нь огцруулах үндэслэл болсон хэмээн УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан тайлбарласан

удаатай. Засгийн газрын нэг жилийн үйл ажиллагаанд 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар ард түмэн үнэлэлт өгсөн. Мэргэжлийн гэх тодотголтой Засгийн газар байгуулагдсан боловч боловсон хүчний сонголт, томилгоонд алдаа гаргасан. Засгийн газрын тодорхойгүй байдал, тооцоо судалгаа муутай эргэж буцсан шийдвэрүүд, цөөн хэдэн хүнийг дэмжсэн үйл ажиллагаа нь намын нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн. Мөн 2016 оны УИХ-ын сонгуульд МАН-ын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн удаашрал нь иргэдийн шүүмжлэлтэй тулгарч байгаа албан бичигтээ дурджээ. Үүнээс гадна Ерөнхий сайдыг танхимаа удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж чадаагүй хэмээн дүгнэж, огцруулах шийдвэрт хүрсэн гэдгээ онцолсон юм. [ЗГМ]

ТОМИЛГОО

АТГ-ын орон тооны бус Олон нийтийн зөвлөлийг бүрдүүлэв

Б.Сүрэн
ЗГМ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга захирамж гаргаж, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх орон тооны бус Олон нийтийн зөвлөлийн гишүүдийг томиллоо. Зөвлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд зөвлөлийн даргаар Ахмадын чөлөөт холбооны тэргүүн Г.Баасанг томиллоо. Харин үлдсэн 14 хүний тухайд УИХ-ын гишүүн асан Р.Бурмаа, Ц.Оюунгэрэл, Баянгол дүүргийн Засаг дарга асан Д.Оросоо, МоАХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн О.Цоодол болон “Шууд ардчилал хүрээлэн” ТББ-ын захирал А.Саруул нар багтаж байна. Мөн “Либерал хаус” бодлогын судлалын

хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Энхбат нарыг орон тооны бус Олон нийтийн зөвлөлийн гишүүнээр томилжээ.

Зөвлөлийн гишүүдийн дийлэнх нь хуульчид болон ТББ-ын гишүүд байна. Тодруулбал, Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Д.Пүрэвбаатар, “Легитимус” ТББ-ын хуулийн зөвлөх, хуульч Б.Анхныбаяр, “Шинэ Улаанбаатар” ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Э.Батсуурь, “Нарны зон” НҮТББ-ын тэргүүн Э.Бямбацэрэн нар Олон нийтийн зөвлөлд багтжээ. Үүнээс гадна “Хамтын халуун сэтгэл” ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Б.Ганхөлөг, “Алтан элч” гэр бүлд эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийн төлөөлөл Д.Дэлгэрбат нар АТГ-ын дэргэдэх орон тооны

бус Олон нийтийн зөвлөлийн гишүүнээр ажиллана. Түүнчлэн бусад салбарын төлөөлөл ч багтжээ. Тухайлбал, Монголын малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн холбооны тэргүүлэгч И.Мөнхжаргал, Техник, загвар зохион бүтээгч спортын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн С.Отгонгэрэл нарыг томилсон байна.

Орон тооны бус Олон нийтийн зөвлөл дөрвөн жилийн хугацаанд ажиллах бөгөөд зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэхээр болжээ. Тиймээс Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд зөвлөлийн гишүүдийг ажиллах боломжоор хангаж өгөхийг АТГ-ын дэд дарга Ц.Нямдорж, Тамгын хэлтсийн дарга З.Баасанням нарт даалгалаа. [ЗГМ]

ЭШЛЭЛ



-Парламентын засаглалтай улс орнуудад Засгийн газарт хариуцлага тооцох, огцруулах асуудал нээлттэй байдаг. Өмнө нь олон Засгийн газарт хариуцлага тооцож байсан. Энэ удаа Засгийн газрыг огцруулах асуудлаар УИХ-ын 30 гишүүн гарын үсэг зурж, өргөн барьсан. Хуулийн хугацаанд асуудлыг хэлэлцэх байх. Засгийн газрын гишүүний хувьд би нэг жилийн хугацаанд гүйцэтгэх засаглал боломжийн түвшинд ажилласан гэж бодож байна. Ялангуяа, эдийн засгийг тогтворжуулах, тодорхой хэмжээний өсөлт бий болгох чиглэлээр ажлууд хийсэн. Үр дүн нь ч эхнээсээ гарч байгаа.

Батлан хамгаалахын сайд

Б.Бат-Эрдэнэ

ЗГМ ТОВЧХОН

» ЕРӨНХИЙЛӨГЧ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Будапештэд болсон жүдогийн ДАШТ-ий нээлтийн дараа ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтэй уулзлаа. Энэ үеэр хоёр улсын Төрийн тэргүүн нар есдүгээр сарын 4-7-нд болох Владивостокийн Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр худалдаа, эдийн засаг, түншлэлийн асуудлаар илүү нухацтай ярилцахаар тохиров.

» УУЛЗАЛТ

Монгол Улс, АНУ, Япон улсын Гадаад харилцааны яам хоорондын гурван талт уулзалт өнөөдөр Улаанбаатар хотноо болно. Энэхүү уулзалтаар нийгэм, улс төр, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа болон Зүүн хойд Азийн аюулгүй байдлыг хөндөнө. Мөн бүс нутгийн интеграци, Улаанбаатарын яриа хэлэлцээ болон олон улсын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцох юм.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол, Японы гадаад харилцаа, аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн байгууллага хоорондын IV зөвлөлдөх уулзалт өнөөдөр болно. Уулзалтаар Монгол, Японы стратегийн түншлэлийн харилцааг улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалахын салбарт бэхжүүлж, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх талаар ярилцана. Мөн олон улс, бүс нутгийн аюулгүй байдлын талаар харилцан санал солилцоно.

» ТОО

100

Тэрбум төгрөг. Засгийн газар өнгөрсөн оны эхний долоон сард дотоод, гадаадын зээлийн хүүнд нийт 403 тэрбум төгрөг зарцуулсан байна. Харин энэ онд 583 тэрбум төгрөг төлж, зээлийн хүүгийн төлбөр өмнөх оноос даруй 100 орчим тэрбум төгрөгөөр өсчээ.

» ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

УИХ-ын гишүүн Ж.Батзандан хичээлийн шинэ жилийн нээлттэй холбогдуулан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бэлтгэл, тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. Тэрбээр багш, сурган хүмүүжүүлэгч нарын цалин, нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор УИХ-ын дэргэд лобби бүлэг байгуулах саналыг дэмжиж байгаагаа дуулгав. Мөн хэлэлцүүлэгт оролцсон багш нарын тавьсан асуудлыг холбогдох байгууллагуудад албан бичгээр хүргүүлнэ.

» МЭДЭГДЭЛ

Цахим ертөнцөөр Шадар сайд У.Хүрэлсүхийг Засгийн газрыг унагаж, Ардчилсан намтай хамтрах шийдвэрийг гаргасан гэх мэдээлэл тархсан. Тэгвэл энэ мэдээлэл худлаа гэдгийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд өөрийн албан ёсны цахим хуудсаараа дамжуулан мэдэгдлээ. Тэрбээр “Энэ миний гарын үсэг биш. У.Хүрэлсүх сайдтай түймэр унтраалцахад цуг явснаас өөрөөр уулзаагүй, бас бичиг солилцоогүй. Гүтгэхээ зогсооё” гэжээ.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZAS.AG

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
СОНИН ХМХ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО
Утас: 99997481

Орлогч эрхлэгч
Лагжаваны СУТАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ
Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Даваатогтох
Утас: 99901637

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтертайментын алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Э.Энхбаатар
Утас: 99903578

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Л.Сутармаа

98658000291124 00709

Нийтлэлчийн булан

Босго нь намдсан Монголын төр

Дэлхийн томоохон орнуудын парламентын гишүүдийн нас харьцангуй өндөр



Парламентын залуу гишүүдийг тойрсон бараан мэдээ, болгоомжгүй үйлдэл, бодлогогүй хэлсэн үгс нь ийн нөлөөлжээ.

Нөгөөтэйгүүр, Монгол төрийн босго намдаж, үнэгүйдсэн бодит жишээг цөөн хэдэн үгээр тэрбээр ийнхүү илэрхийлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд “УИХ-ын гишүүнээр Монгол Улсын 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно” хэмээн заасан байдаг. Хуулиар олгогдсон энэ эрхээ эдэлж өнөөдрийг хүртэл УИХ-ын сонгуульд нас, хүйс, эзэмшсэн мэргэжил, боловсролын түвшин зэрэг олон зүйлээрээ эрс ялгаатай нэр дэвшигчид өрсөлдөж байлаа. Өөрөөр хэлбэл, 25 нас хүрсэн ухаан саруул хэн ч УИХ-д нэр дэвших эрхтэй.

Тэгвэл Улсын Бага Хурал буюу Монголд байнгын ажиллагаатай парламент бий болоход залуучууд улс төрд хүч түрэн орж ирсэн. Энэ нь Монголд ардчилсан хувьсгал өрнөсөнтэй салшгүй холбоотой. Учир нь ардчилсан хувьсгалыг эхлүүлсэн хүмүүсийн ихэнх нь залуучууд байсан нь маш том нөлөө үзүүлж, Монголын улс төрийн өнгө аяс, түүхийг өөрчилсөн юм. Тухайн үед улс төр дэх залуучуудын оролцоо нэмэгдэж, Монгол төрийн бодлого тодорхойлох түвшинд залуусын төлөөлөл багтаж байгаад олзуурхаж байлаа.

Монгол Улсын парламентын түүхээс авч үзэхэд 1990 оны ардчилсан хувьсгалын дараа анхны сонгуулиар бүрдсэн Улсын Бага Хурлын гишүүдийн дотор 30 хүртэлх насны 10 гишүүн ажиллаж байв. Харин 1992-1996 оны УИХ-д 25-35 насны 11 гишүүн байжээ. Гэвч 1996 оноос хойш 35 хүртэлх насны залуу гишүүд орж ирэх нь дараа дараагийн парламентад эрс багассан байдаг юм. Онцлоход, 30 насны босго алхаагүй байхдаа төрийн түшээ болсон гурван тохиолдол бий. УИХ-ын гишүүн асан С.Баярцогт болон Монгол Улсын 28 дахь Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нар 27, 28 насандаа төрийн түшээгээр сонгогдож, саарал ордонд төрийн жолоо атгалцах хариуцлагатай үүргийг хүлээж байлаа. Харин гурав дахь тохиолдол нь 2016 оны УИХ-ын ээлжит сонгуулиар 29 настай Д.Гантулга төрийн түшээгээр сонгогдож, энэ парламентын хамгийн залуу гишүүнээр тодрод буй.

Гэхдээ өнгөрсөн 25 жилийн хугацаанд монголчуудын бодол санаа өөрчлөгдөж, парламентын гишүүний насны босгыг нэмэгдүүлэх шаардлага байгааг нэг бус удаа хөндөж, Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд дээрх заалтыг эргэн харахыг санал болгож байсан

юм. Учир нь парламентын залуу гишүүдийг тойрсон бараан мэдээ, болгоомжгүй үйлдэл, бодлогогүй хэлсэн үгс нь ийн нөлөөлжээ.

Монгол Улсын парламентын гишүүдийн 14.3 хувийг залуучууд эзэлж байна

УИХ-ын залуу гишүүд улс орны эрх ашиг гэхээс илүүтэй өөрсдийнхөө төлөө амбийц хөөж, төрийн ажлаас хойш нь чангаадаг. УИХ-ын гишүүн гэдэг төрийн бодлого тодорхойлодог, улс орны ирээдүйг “зурахад”

онцгой үүрэг гүйцэтгэдэг. Хууль санаачлах, хэлэлцэх, батлах нь тэдний үндсэн ажил. Тиймээс цэвэрлэгч, ачигч, манаачийг ажилд авахдаа дээд боловсрол эзэмшсэн, эсэхээр нь дугаарладаг манайх шиг орон төрийн эрх барих дээд байгууллагадаа ажиллах хүнд түүнээс өндөр шаардлага тавьж, наанадаж насны босгыг нь нэмэгдүүлж, төлөвшсөн парламент бүрдүүлэх учиртай.

Гэтэл ажил, амьдралын туршлага, төрийн хүний зангарга, мэдлэг чадвараар гэхээс илүү намын даргын тойрон хүрээлэгч, фракцуудын тохиролцоо болон бэл бэнчинтэй нь хандив өгсөн нэрийдлээр сонгуульд нэр дэвшиж, төрийн түшээ болсон тэднийг танхимын гишүүд нь байтугай жирийн иргэд хүртэл голж байна. Бас өмнөөс нь ичиж,

санаа зовж байна.


Энэ бүх зүйл УИХ-ын гишүүнд нэр дэвшигчдэд тавих шалгуур, шаардлага сул байгаатай холбоотой. Гэтэл гаднын орнуудын тогтолцоо эсрэгээрээ. Нийгэм, эдийн засгийн харилцааны онцлог, улс төр, эрх зүйн соёлын түвшин нээс хамааран парламентын сонгуульд нэр дэвшигчдэд тавих шалгуур өөр өөр байдаг. Төрийн жолоогоо атгуулах бодлого тодорхойлогчдоо сонгохдоо гэр бүлийн хүмүүжил, амьдралын туршлага, хувь хүний үзэл бодол, ёс зүй, хууль дээдлэх эрхэм ёс гээд олон зүйлийг шалгуур болгодог байна. Нөгөөтэйгүүр, нэр дэвшигчийн насанд ч онцгой анхаарал хандуулдаг аж. Тухайлбал, АНУ-ын Конгрессын төлөөлөгчдийн танхимын гишүүнд нэр дэвшигч

25 нас хүрсэн байх ёстой бол Сенатад нэр дэвшигч 30 нас хүрсэн байх ёстой. Олон улсын парламентын холбооноос өнгөрсөн онд дэлхийн 128 орны парламентын гишүүдийн насны бүтцэд судалгаа хийжээ. Казахстан улсын парламентад 40-өөс доош насны гишүүд нь нийт гишүүний 1.9 хувийг эзэлж байна. Өмнөд Солонгосын хувьд энэ үзүүлэлт 2.3, харин Хятад 5.6, АНУ 6.7, Франц 7.6 хувийг эзэлдэг гэсэн судалгааг гаргажээ.

Харин Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллагын гишүүдийн 14.3 хувийг залуучууд эзэлж, энэ үзүүлэлтээрээ судалгаанд хамрагдсан дэлхийн 128 орны тэн хагаст эрэмбэлэгдэж байна. Дээрх судалгааны дүн нь зөвхөн доод болон нэг танхимтай улс орнуудынх. Дээд танхимтай

орнуудын хувьд Англи улс тэргүүлж байна. Тус улсын 40-өөс доош насны парламентын гишүүд нь нийт гишүүний 0.6 хувийг эзэлдэг. Франц, Канад, Америк, Бразил, Аргентин болон Энэтхэг улсын хувьд мөн л бага үзүүлэлттэй байгаа бөгөөд 1.2-3 хувийн хооронд хэлбэлздэг байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн томоохон орнуудын парламентын гишүүдийн нас харьцангуй өндөр байгаа юм. Манай улс ч гэсэн Үндсэн хуулийнхаа дээрх заалтыг эргэн харж, парламентын гишүүний насны босгыг зайлшгүй нэмэх шаардлага тулгарч байгааг бусад улс орнуудын жишиг төдийгүй Монголын улс төрд өрнөж буй үйл явдлууд харуулсаар байна. Бид Монгол төрийн босго ямагт өндөр байх учиртайг байнга сануулсаар ирсэн ард түмэн. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭВРИКА
Bloomberg TV Mongolia

“Эврика” нэвтрүүлгээр орчин үеийн урлагийн ертөнцийн амин сүнс, цохилох зүрх болсон гайхшруулж, оюун бодлыг сорьж, алмайруулж чаддаг гоц авьяастнуудтай уулзуулдаг. Энэ удаагийн дугаарт бид БНСУ-ын уран бүтээлч Ли Бүлийг танилцуулах болно. Өмнөд Солонгосын түүхэн дэх цөвүүн цагт төрж өссөн Ли Бүл үеийнхэн дундаасаа цойлон гарч ирсэн уран бүтээлч бөгөөд үзүүлбэр урлагаас эхлээд уран баримал, инсталляци гээд олон хэлбэрээр бүтээл туурвидаг нэгэн.

Пүрэв гараг /2017.08.31/

20:30

11:30 Баасан гараг

15:30/21:30 Бямба гараг

20:30 Ням гараг

Авто

СОНИРХУУЛАХАД



Анхны жолооч

Тэрбээр унадаг дугуйгаар Богдын хүрээнд иржээ

1919-1920 оны үед Нийслэл хүрээнд арваад автомашин байснаас ихэнх нь Богд хааны байв. Тэдгээр машиныг жолоодох, засаж, сэлбэх ажлыг хааны ордныг цахилгаанаар гэрэлтүүлэхийн чалуу цаг засдаг, хувьдаа мотоциклтой В.Бадам гэгч хүн хариуцдаг байжээ. Богд хаан залрах үед уурын тэргийг нь жолоодож явсан Бадамыг Монголын хамгийн анхны жолооч, механикч байсан тухай түүхэнд өгүүлдэг. Вампилын Бадам 1886 онд одоогийн ОХУ-ын Буриадын Онон хэмээх газар мэндэлж 1910 оны үед унадаг дугуйгаар

Богдын хүрээ буюу одоогийн Улаанбаатарт иржээ.

Тэрбээр нэг хэсэг айлын оёдлын машин, дугуй, цаг засах зэргээр амь зууж явсан гэдэг. Түүний тухай яриа цаг цуглуулж элдэв оньс техник сонирхдог байсан наймдугаар Богд Жавзандамба хутагтын сонорт хүрснээр Бадамыг ордондоо залж, жолоочоо болгосон юм.

Хааны жолоочоор гурван жил ажилласныхаа дараа Телефон утасны хорооны механик болжээ. 1921 онд Ардын хувьсгал ялсны дараа Богд хааны жолоочоор дахин ажиллаж байгаад 1924 онд хааныг таалал төгссөний дараа зургийн болон цаг засварын газар ажиллуулдаг байв. Тэрбээр 1935 онд Кино зургийн хороо байгуулагдахад фото зурагчин, кино механикийн ажлыг хийж байжээ. [ЗГМ]

Эйр кондишн

Салоны агаар хөргөх төхөөрөмж буюу эйр кондишны ажиллагааг энгийнээр тайлбарлая. +25 хэмийн тасалгаанд нэг кг мөс тавилаа гэж бодоход физикийн дулаан солилцох үйлчлэлээр өрөөний хэмээс мөс авч, эсрэгээрээ хүйтэн мөс өрөөг +23 хэм хүртэл бууруулна. Үүний адилаар эйр кондишн систем нь битүүмжтэй хөргүүрээс халуун агаар аваад салоныг хүйтэн салхиар үлээлгэж, хөргөдөг.



АЖИЛЛАХ ЗАРЧИМ:

1. Эйр кондишны мотор нь хийн төлөвтэй фреоныг машины радиатор руу өндөр даралтаар шахна.
2. Радиатороор дамжих фреон хөрж шингэн төлөвтэй болонгуут шингэн нь ууршуулагчаар хөрж салоны радиаторыг хөргөдөг.
3. Салоны хөрсөн хүйтэн радиатор руу сэнс үлэсэнээр хүйтэн агаар машиныг хөргөнө.
4. Энэ үед салоны хүйтэн радиатор руу халуун агаар цан цохиж доошоо ус дусална.

Дөч гарсан Prius дөрөв дарсан ат



Машин илүү өнцгөн хэлбэртэй болж, аэродинамик эсэргүүцэх коэффициент нь 0.24 хүртэл багассан.

Би цаг үеэсээ түрүүлсэн машинд ороод ирэв

Н.Анир
ЗГМ

Toyota-г хөгжлийн эсрэг хуучинсаг үзэлтэй гэх хүмүүс бас байдаг юм байна. Сонин байгаа биз. Гэтэл Toyota компани цөөхөн ч гэсэн устөрөгчөөр явдаг Мiгаi-г үйлдвэрлэлд оруулаад амжсан. Цаашилбал, автомашины хөгжлийн түүхийг орвонгоор нь өөрчилж, өдгөө 20 дахь жилийн нүүрийг үзэж буй гибрид Prius-ын тоо дөрвөн саяын босго давчихлаа. Тиймээс дөрөвдүгээр үеийн Prius худалдаанд гарсан тул туршиж үзэх сэдэл төрлөө.

Европ болон Америкийн зах зээлийг цахилгаан хүлэг эзлэх эл цагт шинэ Prius-ийг бас л ялгаагүй “цахилгаанжих” байлгүй гэж бодтол тэгсэнгүй. Хөдөлгүүр нь хуучнаараа гибрид. Цэнэглэдэг Prius мэдээж цэнэглэх станцгүй улс оронд орж ирэхгүй.

Дугуй хоорондын зай нь өөрчлөгдөөгүй ч машины их бие илүү уртсаж, өргөссөн. Кузовт шинэ, бат бөх ган төмөр ашигласнаар бүх жин 50 кг багасав.

Хойд тэнцүүлэгчийн оронд үл хамаарах тэнхлэг суурилуулж, багаажид байсан аккумуляторыг капот руу шилжүүлж, 28 ширхэг батареийг арын суудал руу шилжүүлсэн.

Дагуул араа бүхий цахилгаан механик CVT нь хамаагүй авсаархан болж хөнгөрчээ. Цахилгаан мотор нь мөн адил хэдэн арван мориор хүчээ нэмж 72 болсон. Бензин хөдөлгүүр нь хуучны адил 98 морины хүч гаргана. Сайжруулсан оруулах хоолой, шинэ хөргөх систем, дахин ашигладаг хийн шаталтын ачаар ашигт үйлийн коэффициент 40 хувьд хүрч, автомашин үйлдвэрлэлийн дээд амжилтыг тогтоох нь тэр. Энэ бүхний үр дүнд шатахуун зарцуулалт таван хувь багасав.

УЛААН ЦЭНХЭР ЖИГҮҮР

Ингээд сайжирсан эсэхийг нь шалгахад улаан жигүүрт шинэ Prius 40, харин цэнхэр жигүүрт өмнөх үеийн Prius 30-ийг урья.

Урьд нь надад Prius 30 их л шинэ, ихийг амласан автомашин шиг санагддаг байлаа. Харин одоо эргэлзэж эхэллээ. Салон нь нэг л бүүдгэр, саарал. Толгойд хамгийн тод үлдсэн юм нь жолооч зорчигч хоёрын хоорондох аварга том зай. Араагаа D-рүү шилжүүлээд явцгаая.

Байрнаасаа батареийгаар хөдөлж минутын дараа дотоод

шаталтат хөдөлгүүр нь ажиллагаанд орно. Эвдрэл гэмтэлтэй замаар мөлхөх зуур салонд дугуйны дуу чимээ хүнгэнэж, сонсдох юм. Засмал зам руу гарвал яадаг бол. Цаг алдалгүй гарч хаазалъя.

Зөв зөв, төдийлэн сайн хурдалдаггүй юм байна. Дээрээс нь их дуу чимээтэй. Эргэлтээр орж гарахдаа болхи. Гулгаа савхин бүрээстэй хэрнээ бүсэлхийн ямар ч түшлэггүй суудал нь галзууртлаа давчих хүсэл эрмэлзэл төрүүлсэнгүй. Гэхдээ хэзээ байтлаа Prius-ээр давхиж нисдэг байлаа даа. Уг зориулалт нь тийм биш шүү дээ.

Хэсэг явлаа, хангалттай. Одоо шинэ Prius 40-д шилжсэн замаар дугуйн чимээ огт сонсогдсонгүй. Эргэхэд жолооны хүрд нь түүртэхгүй, замтай сайн барьцалдана. Хурд авалт хэвээрээ ч өмнөх үед бодвол хааз, тоормосны гишгүүр нь илүү хурдан үйлдэлтэй.

EV горимоо асаагаад шулуун зам руу мөлхлөө. 1.3 кВт-ц багтаамжтай батареийгаар шалихгүй, 1.5 км зам туулна. Хэмнэлт болон хурд авалт хоёрыг хослуулсан Normal

горим руу шилжлээ. Олон ачааны машинтай, хажуугаар нь зөрөх зайгүй байхаар нь хурд түгжигч Cruise Control-оо асаагаад тааваараа давхилаа.

Явж байтал шалаанз хооронд багахан зай гарахаар нь Power горим руу шилжүүлээд тултал нь хаазаллаа. Уг нь урагшаа ухас хийх хэрнээ 110 км/ц дээр ирээд үл үзэгдэх хана тулсан мэт хамаг хөдөлгөөн хязгаарлагдана.


Хурдны замынх шиг бензин хэмнэсэнгүй. Бараг л тоормос гишгэлгүй нэгэн хэвийн хурдаар явсан гэхээр мэдээж цэнэг хураах систем нь ямар ч энерги хураахгүй. Би 100 км-т 4.8 литр шатахуун зарцуулаа. Орой буцахдаа түгжрэлд ороод бензин идэлт багасах нь баараггүй. Хөөрсөндөө бүр Eсо горимоо асаагаад явтал шатахуун зарцуулалт 100-д 4.5 литр болсонд өөрийгөө магтаад авлаа.

Гэвч 90 сая төгрөгийн үнэтэй энэ машинд хоёрын хооронд хагас аяга бензин хэмнээд хэрэг нь гарах уу. Ийм зэргийн мөнгөөр Toyota Camry эсвэл RAV4-тэй болж болно. Бүр сэргэлэн нөхдүүд Land Cruiser Prado ч авчихна.

Намайг дизайны талаар нэг ч үг дуугараагүйг анзаарсан уу. Prius 40-ийн харагдах байдал нь цаанаа л өөр. Толгой эргэм хурц ирмэгүүд нь арай л хэтэрхий санагдана. Яг үнэтэйгээ адилхан гээд л ойлгогчийг. [ЗГМ]




Ийм жижиг араа шилжүүлэгчид Prius-ийн жолооч нар аль хэдийнэ дассан биз. Анх Prius 20 дээр гарч байсан товчлуулаар идэвхждэг parking горимыг одоо олон үйлдвэрлэгч санааг нь авч амжилттай хэрэгжүүлж байна.



Хянах самбарыг салхины шилэн дээр тусгал дэлгэцээр харж болно. Жолоо барьж байхад сагаарахгүй, бүх юм нүдний урд ил.



Салоныг гэгээлэг эсвэл бараан мөртлөө цагаан оруулгатай гэсэн хоёр янзаар захиалж болно.



ЭВДРЭЛ ГЭМТЭЛ:

Эйр кондишны хоолойнууд ямар ч цоорхой, хагарч, хугарсан юмгүй, бүрэн битүүмжлэгдсэн байх ёстой. Гэмтэл үүссэн тохиолдолд фреон алдагдаж хүйтнээр үлээхээ боливол тэр даруйд нь яаралтай битүүмжлэх шаардлагатай.

- Ашиглалтын явцад кондишны моторыг залгаж, салгадаг рэлий ажиллагаанаас гарах, холболт авахгүй бол шинээр солино.
- Кондишны моторын шаарик гацаж, ремен суларснаас болж доголдол үүсч, дуу ордог. Энэ тохиолдолд кондишны шаарикийг дангаар нь эсвэл моторыг бүтнээр нь солих хэрэгтэй.
- Фреоныг машины номон дээр заасан даралтын дагуу шахна. Хэт их эсвэл хэт бага даралттай шахвал мотор ажиллагаанаас гардаг.
- Салоны агаар шүүгчийг солиогүйгээс болж салон болон машины урд радиатор битүүрч бөглөрөх, агаар нэвтрэлт муудах, хүйтнээр үлээхээ байдаг. Энэ үед салоны агаар шүүгчийг шалгаж шаардлагатай бол солиулна. **Зарулам**

Нийгэм



С.Батсайхан / ЗГМ©

Тооцоолоогүй шийдвэрийн уршиг

Зүүн эргэхийг хориглосноор нэг автомашины явах зай 1.2 км-ээр нэмэгджээ

Замын хөдөлгөөнд оролцож буй 356 мянга гаруй тээврийн хэрэгсэл 100 км-т дунджаар 10 литр шатахуун зарцуулдаг гэж тооцвол жолооч нар нэмэлт 1.2 км тутамд 195 төгрөгийг зөвхөн тулшинд зарцуулж байна. Үүнийг нийт автомашины тоогоор илэрхийлбэл 69.4 сая орчим төгрөг болно. Цаашлаад 42.6 мянган литр бензинээр агаар бохирдуулж байна.

Хөдөлгөөнт тээврийн хэрэгслээс ялгарч буй утаанд 260 гаруй төрлийн хорт бодис агуулагдах гэх судалгаа бий. Үүний зонхилох хэсэг нь нүүрстөрөгчийн давхар исэл. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар энэхүү хий хүний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөгөөрөө цацраг идэвхт бодисын дараа буюу хоёрдугаарт ордог. Ийм хорт хийн 90 хувь хөдөлгөөнт эх үүсвэрээс бий болдог гэж олон улсад үздэг. Өдгөө дэлхий дахины тулгамдсан асуудлын нэг болоод буй хүлэмжийн хийн гол үүсгэгч ч нүүрстөрөгчийн давхар исэл.

Соёлтой, шуурхай үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учруулж буй гэв

Ингээд бодохоор механикаар илүүчилсэн 1.2 км тутмаас бид хүний эрүүл мэнд, байгаль орчинд ямар их сөрөг нөлөө бий болгож буйг түвэггүй ойлгохоор. Нөгөөтэйгүүр, туслах замуудын ачаалал эрс нэмэгдсэнээр автомашинд өнгөрүүлэх хугацаа өдөрт дунджаар 30 минутаас нэг цаг болж уртассан гэж жолооч нар бухимдаж байна. Тухайлбал, Баруун болон Зүүн дөрвөн замын хооронд ихэнхдээ хөдөлгөөнд оролцдог ДАР 0244 улсын дугаартай, спорт загварын "Toyota Verossa" маркийн машины жолооч, 25 орчим насны залуу "Ядаж л гэрээсээ маш эрт гарах хэрэгтэй болж байна. Түгжрэл дунд машиндаа өдөрт бараг 40 минут илүү өнгөрүүлдэг болж байна" хэмээв. Түүний машин 100-д 18 литр түлш зарцуулдаг аж. Өмнө нь өдөрт 10 литр бензин хийдэг байсан бол одоо энэ тоо хоёр дахин нэмэгдсэн гэнэ.

Албаныхны хэлснээр бол бараг бүтэн жил судалж байж гаргасан эл шийдвэр бидэнд тэр бүр анзаарагдахгүй уршигийг бий болгожээ. Энэхүү

шийдвэр тээврийн хэрэгслээр амьдралаа залгуулдаг хүмүүст хэрхэн нөлөөлж буйг сураглан "Улаанбаатар такси" компанийг зорьсон юм. Нийт 267 таксинаас 150 нь үйлчилгээнд байнга гардаг тус компанийн жолооч нар "Зүүн эргэхийг хориглосон шийдвэрийн сайн тал гэж огт алга" хэмээн хатуухан хэлж байна.

Өдөрт 14-15 дуудлага хүлээж авдаг байсан бол одоо арай гэж 10 дуудлагад үйлчилж буй талаар тэд ярилаа.

Тус компанид хоёр жил гаруй ажиллаж буй 50 орчим насны нэгэн жолооч "Төв зам дагуу явж байхад "Хобби" сургуулиас дуудлага ирлээ гэхэд "Багшийн дээд"-ийн уулзвараар зүүн эргэж болохгүй тул тойрч очно. Ингэж явсаар дуудлагын цагаас 5-10 минут хоцорч байна. Эсвэл түгжрэлд ороод таг зогсчихно. Бас үйлчлүүлэгчид 1500 төгрөг төлөөд хүргүүлчих байсан зай нь 2000 төгрөг болж нэмэгдэхээр бухимдана" гэсэн юм. Энэ мэт олон зүйл соёлтой, шуурхай үйлчилгээ үзүүлэхэд маш их хүндрэл учруулж буйг жолооч нар учирлаж байна.

- **Замын хөдөлгөөнд оролцож буй 356 мянган тээврийн хэрэгсэл 100 км-т дунджаар 10 литр шатахуун зарцуулдаг гэж тооцвол жолооч нар нэмэлт 1.2 км тутамд 195 төгрөгийг зөвхөн тулшинд зарцуулж байна.**
- **Үүнийг нийт автомашины тоогоор илэрхийлбэл 69.4 сая орчим төгрөг болно.**
- **Цаашлаад 42.6 мянган литр бензинээр агаар бохирдуулж байна.**

Төв зам дагуух долоон уулзвараар зүүн гар тийш эргэх хөдөлгөөнийг хориглосон шийд-

вэрээ эргэн харж, судалж үзэхийг Ерөнхий сайд хотын даргад үүрэг болгосон. Харамсалтай нь, энэ үүргийн биелэлт Бөхийн өргөөний уулзвараар хязгаарлагдаж, "нүглийн нүдийг гурилаар хуураад" өнгөрлөө. Мөн мягмар гарагт нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч Н.Багсүмбэрэл хотын даргад зүүн гар тийш эргэхийг хориглосон шийдвэрээ нэн даруй цуцлахыг хүссэн албан бичиг хүргүүлээд буй.

Замын хөдөлгөөнийг зохицуулах олон арга хэмжээ хэрэгжүүлж буй ч ачаалал буурахгүй байгаа нь нийслэлд автомашин багтаж шингэх орон зай байхгүй байгаагийн илрэл. Гэтэл номхон тэмээ ноолоход амар, ноомой хүн зарахад амар гэгчээр шийдвэрийг нь дагахгүй хаачих билээ гэж хүчлээд ч нэмэргүй болсныг шийдвэр гаргагчид мэдэхийн дээдээр мэдэж буй. Эцсийн дүндээ доголлон судалгаа, харгалзан шийдвэрийн балгийг ард иргэд, аж ахуйн нэгжүүд нуруун дээрээ үүрэх гэж үйлээ үзэх учир ардчилсан нийгэмд баймааргүйсэн. [ЗГМ]

ЗГМ: НЭГ АСУУЛТ


Зүүн гар тийш эргэх хөдөлгөөнийг хориглосноос иргэд, жолооч нар цаг хугацаа, эдийн засгаараа хэр зэрэг хохирч буй талаар сонирхлоо.



"Витафит" компанийн түгээлтийн автомашины жолооч

Т.Булгантамир:

"Туулдаг зай нэг их өөрчлөгдөөгүй. Түгээлтийн машинууд угаасаа төв замаар зорчих хориотой. Харин туслах замуудад үүссэн ачааллаас болж цаг хугацаа, түлш зарцуулалт эрс нэмэгдсэн. Бид өдөрт 100 гаруй дэлгүүрт түгээлт хийдэг. 08.00 цагаас түгээлтээ эхэлж 19.00 цагт буудаг байсан бол одоо 22.00 цаг өнгөртөл дуусахгүй байна. Бас долоо хоногт нэг удаа машиныхаа шатахууныг дүүргэдэг байсан. Харин сүүлийн 14 хоногийн хугацаанд долоо хоногт хоёр удаа дүүргэж байна.



Жолооч Н.Зоригт:

"Чигээрээ хөдөлгөөн сайн явж байна. Гэвч энэ шийдвэрийн уршиг хамгийн их мэдрэгдэж байгаа туслах замуудад замын цагдаа нар ажиллаад ч хүчрэхгүй байна. Бас авто зогсоолгүйн улмаас нэгдүгээр эгнээнд машинууд их зогсож байна.

Үүнээс механик түгжрэл бий болсон. Миний хувьд төв замаар л болж өгвөл зорчих юмсан гэж бодож байна. Уг нь бэлтгэлээ сайн хангаад хавраас эхэлсэн гол замын хөдөлгөөн өдийд гольдролодоо орчих байсан болов уу.



"Улаанбаатар такси" компанийн тээвэр, техникийн хэлтсийн менежер

Д.Ариунболд:

"Авто тээврийн хөдөлгөөнтэй холбоотой мэргэжлийн олон байгууллага бий. Тэднээс болон манайх шиг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийнхний байр суурийг авч, иргэдийн сэтгэл санааг бэлтгэж байж энэ шийдвэрийг гаргах хэрэгтэй байсан. Сургууль, цэцэрлэгийн бэлтгэл гээд хөдөлгөөн ид өрнөж буй үед гэнэт өөрчлөлт хийсэн тул учраа олохгүй хүн олон байна. Долоохон хоногийн хугацаанд зарлаад, хэрэгжүүлчихсэн юм чинь аргагүй шүү дээ.

Такси нь нийтийн тээвэр тул дугаарын хязгаарлалтад ордоггүй, нэгдүгээр эгнээгээр чөлөөтэй зорчдог. Тиймээс



"Улаанбаатар такси" компанийн УНМ 12 45 дугаартай таксинь жолооч

Н.Билэгсайхан:

"Зүүн гар тийш эргэх хөдөлгөөнийг хориглоогүй байхад өдөрт 100-120 км явж, 50-60 мянган төгрөгийн орлоготой ажилладаг байлаа. Өчигдөр ердөө 30 гаруй мянганхан төгрөг л олсон. Үүний 20 мянгаар нь бензин хийсэн. Үлдсэн дээр нь таван мянган төгрөг нэмчихвэл тушаах орлогодоо хүрэх гээд л зовж явна. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...



Та доорх кодыг уншуулж Засгийн Газрын Мэдээ Financial Times сонинг нэг дороос уншина уу



Та QR code уншуулахын тулд App Store-оос QR reader татаж суулгана уу.

70103131, 99903581, 99903584
info@zasag.co
Zasag.Co



Спорт

Жүдог үндэсний спорттойгоо хослуулан өөрийн арга барилыг бүрдүүлж чаджээ

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Нэгэн цагт өвөг дээдэс маань зэр зэвсгээ агсаад буурал тивийг дайлаар мордож байлаа. Тэгвэл өдгөө спортоор дамжуулан улс орныхоо сүр хүчийг үзүүлдэг болжээ. Чөлөөтийнхөн хэдхэн хоногийн өмнө Францын нийслэл Парист гялалзтал барилдаж, алт, хүрэл медаль нэгжээдийг хүртсэн бол залуулаад жүдочид Унгарын Будапештэд, боксчид Германы Хамбургт амжилттай “үзэлцэж” явна.

Ердөө арав гаруйхан жилийн өмнө Монголын тамирчид дэлхийн дэвжээнээс медаль авах нь мөрөөдөл шахам байлаа. Хааяа л нэг медаль авчирна. Түүндээ хөөрч баярлана гэж жигтэйхэн. Тэдэн жил тасарсан медалийг авчирлаа гээд л. Гэтэл одоо байдал өөрчлөгджээ. Сая чөлөөтийн тамирчид нэг алт, нэг



ijf.org®

Унгар, Германыг дайлаар мордсон тэмдэглэл

хүрэлтэй ирэхэд голох маягтай байна шүү. Мэдээж үүнээс илүү амжилт гаргах боломж байсан болохоор ингэж хандсан. Харин одоо бокс, жүдогийнхоос бүр ч илүү амжилт хүлээн суугаа нь тодорхой.

Жүдочдын хувьд дэлхийн аваргын гараагаа сайхан эхлүүлж, нээлтийн өдөр мөнгө, хүрэл медальтай болоод авав. Ингэснээр багийн дүнгээр аман хүзүүдэж, Японы ард бичигдэж эхэллээ.

2013 онд дэлхийн аварга болж, бөмбөрцөгт нэрээ данслуулсан М.Уранцэцэг хэдэн жил санасандаа хүртэл барилдаж чадахгүй байсны эцэст энэ удаа мөнгөн медалиар цуглуулгаа арвижуулав. Ингэснээр дэлхийн аваргын хос медальтай хоёр

дахь бөх ийн болж байна. Хэвтээ барилдаанд хэнийг ч гаргаахгүй гэдгээ дахин нэг харууллаа, манай аварга. Бага зэрэг аз түшсэн бол дахин түрүүлчих ч боломж байв. Бүгдийн эмээж байсан дэлхийн аварга япон бөхийг түүртэлгүй ялахыг нь харахад яах аргагүй ид үедээ яваа нь ойлгогдоно. Жүдочдоо дэмжихээр Унгарт очоод буй шинэхэн Ерөнхийлөгч Х.Баттулга түүний медалийг гардуулсан нь тохиолдлын явдал биш байв.

М.Уранцэцэгийн дараа буюу 2014 онд дэлхийд түрүүлсэн бөх бол Г.Болдбаатар. Шавилхан биетэй ч асар их бяргай, элдэвтэй барилдаантай тэрбээр энэ удаа хүрэл медаль дээр бууж, мөн л хос медальтны эгнээнд нэгдлээ.

Олимпын медальт узбек эрд цаг сунгаад хожигдоогүй бол шагналын дээд тавцанд дахин гарсан байхыг ч үгүйсгэхгүй. Тэрбээр тэмцээний дараа “Нэлээд хүнд сугалаа татсан. Шөвгийн наймд орохын төлөө сүүлийн хэдэн тэмцээнд дараалж түрүүлээд байсан Японы залуу тамирчинтай таарч хожлоо. Медаль авсандаа баяртай байна” хэмээн ярьжээ.

Энэ өдөр өөр нэг монгол бөх шагналын тавцанд зогссон. Энэ бол Казахстаны нэр дээр барилдаж буй Г.Отгонцэцэг. Одоогоор казахууд ДАШТ-ээс ганц медаль аваад байгаа нь манай Г.Отгонцэцэгийнх. Бид дэлхийн хэмжээний тамирчин өчнөөнөөр нь бэлдэж, зарим нь дотооддоо багтаж шингэж

Он	Хаана	Нэр	Жин	Медаль
1989	Белград	О.Балжинням	95 кг	Мөнгө
1989	Белград	Д.Баттулга	60 кг	Хүрэл
2005	Каир	Х.Эрдэнэт-Од	57 кг	Хүрэл
2009	Роттердам	Х.Цагаанбаатар	66 кг	Алт
2010	Токио	Х.Цагаанбаатар	66 кг	Хүрэл
2010	Токио	М.Бундмаа	52 кг	Хүрэл
2013	Рио	М.Уранцэцэг	48 кг	Алт
2013	Рио	Д.Амартүвшин	60 кг	Мөнгө
2014	Челябинск	Г.Болдбаатар	60 кг	Алт
2015	Астана	С.Ням-Очир	73 кг	Хүрэл
2015	Астана	Д.Сумъяа	57 кг	Хүрэл
2015	Астана	Ц.Мөнхзаяа	63 кг	Хүрэл
2017	Будапешт	М.Уранцэцэг	48 кг	Мөнгө
2017	Будапешт	Г.Болдбаатар	60 кг	Хүрэл

2017.08.28-ны байдлаар

чадалгүй харь орны нэр дээр хүч үзэж эхэлсний тод жишээ нь энэ болж байна. Түүгээр ч үл барам Э.Базаррагчаа (48 кг), П.Буянхшиг (52 кг), М.Ичин-

хорлоо (57 кг) гэсэн өөр гурван бөх Азербайжаны нэр дээрээс барилдаж буйг энд онцолъё.

Монголын хоёр бөх шагналын тавцанд зэрэгцэн зогсож байх

үед тэмцээний албан ёсны сайтын хөтлөгч нь манай орныг гуравхан сая хүнтэй хэрнээ гайхалтай авьяаслаг ард түмэн, жүдог үндэсний спорттойгоо хослуулан өөрийн арга барилыг бүрдүүлж чаджээ хэмээн магтсан. Г.Отгонцэцэгийн багш Д.Энхбаатар “Уг нь бид хоёр аварга болох зорилготой байсан. Отгоо маань жаахан хашир барилдчихлаа. Уг нь өөрөө мэх хийсэн боловч нөгөө талд оноо өгчихсөн. Гэхдээ ямар ч байсан олимп, дэлхийн медальтан боллоо. Сайхан байна” хэмээн сэтгэгдлээ илэрхийлжээ.

Эхний өдөр манай гурван бөх тэмцээнээ өндөрлүүлсэн бол цаана нь дахин 16 хүчтэн ээлжээ хүлээж байна. Өчигдөр Г.Хэрлэн, Б.Хорлоодой, Ч.Азаяа нар дэвжээнд гарсан юм.

Монголын гурван бөх Азербайжаны нэр дээр барилдаж байна

Боксын ДАШТ-д манайхаас харьцангуй цөөхөн буюу дөрвөн тамирчин оролцож байгаа. ДАШТ-д өрсөлдөхийн тулд тивийн аваргаасаа эрх авдаг болсон тул оролцох тамирчны тоо ийн цөөрчээ. Гэхдээ манайхан цөөхүүдээ гээд шантарсангүй, бүгд медалийн төлөө өрсөлдөхөөр шалгараад байв. Тэд урд шөнө медальтай үлдэх, эсэхээ шийдэх чухал тулааныг хийсэн. Олон улсын боксын холбоо (АИВА)-ны албан ёсны сайтад энэ талаар “Монголын боксчид 100 хувийн бүрэлдэхүүнтэйгээр медалийн төлөөх тулаанд гарч ирлээ. Боксын баялаг уламжлалтай энэ баг 2008 онд Э.Бадар-Ууган олимпын аварга болсноос хойш дахин сэргэсэн. Харин одоо шинэ үе нь гялалзтал тоглож байна” хэмээн бичжээ.

Өчигдрийн байдлаар 31 орны тамирчид медалийн төлөөх даваанд тунаа үлдээд байсан. Узбекистаны есөн боксчин торойн хоцорч, бусдыгаа тэргүүлсэн бол Куба найм, Казахстан долоо, дэвжээний эзэн Герман зургаа, Колумб, Англи, Монгол, АНУ-аас тус бүр дөрвөн хүн үлджээ. Тивээр нь авч үзвэл Европын 27, Азийн 26, Америк тивийн 21 боксчин энэ даваанд шалгарсан юм. [3ГМ]

СПОРТ БА МӨНГӨ

Тэрбумтны эгнээ нэгээр нэмэгдлээ

Өмнө нь энэ жагсаалтад М.Жордан, Т.Вудс гэсэн хоёрхон тамирчин байв

Б.Энхжин
ЗГМ

Тулааны спортын түүхэнд үлдэх нэгэн чухал үйл явдал өнгөрсөн долоо хоногт болж, мэргэжлийн боксын дэлхийн аварга асан Флойд Мейведер холимог тулааны босоо аварга Коннор Макгрегорыг хүнд цохилтоор буулгаж авсан. Энэхүү тулааны талаар хэвлэлүүд хангалттай ихийг бичсэн тул дахин нуруаад яахав. Харин Мейведер 10 раундын тоглолтын дараа 400 сая ам.долларын шагнал авснаар тэрбумтан тамирчдын эгнээнд нэгдэн орж байна. Өмнө нь энэ жагсаалтад сагсчин Майкл Жордан, гольфчин Тайгер Вудс гэсэн хоёрхон тамирчин байв.

Спортын талбарт амжилт гаргахын төлөө хөлс хүчээ харамгүй зориулж, эцэст нь тэрбумтан болтлоо баяжиж чадсан энэ гурван тамирчны замналыг сонирхууль.

ТАЙГЕР ВУДС

Цагтаа цалгиж, дэлхийн



ВВМ©

шилдэг гольфчдын тэмцээнд завсаргүй түрүүлж явсан үе түүнд бий. Гольф угаас

шагналын сан өндөр спорт учраас тэр хэрээр хэтэвч нь зузаарсаар байлаа. Улмаар

2009 онд “Форбс” сэтгүүл түүнийг спортоос төрсөн анхны тэрбумтан болсныг албан ёсоор

зарлажээ. Тэрбээр ид үедээ жилд 100 саяыг олох нь энгийн үзэгдэл байв.

Харамсалтай нь, энэ домогт тамирчин сүүлийн жилүүдэд барцадтай байна. Архи, шоу цэнгээнд донтохын хэрээр амжилт нь эрс уруудсан. Мөн согтуугаар машин жолоодож яваад осол гаргаж, цагдаад саатуулагдсан удаатай. Энэ мэт шалтгааны улмаас хөрөнгө нь нэлээд багасчээ. Гэхдээ л могой гурав тасравч гүрвэлийн дайтай гэдэг шиг их савны ёроол яаж дундрахав. Хамгийн сүүлийн тооцоогоор түүний нийт хөрөнгийг 740 сая ам.доллар гэж үнэлсэн байна.

МАЙКЛ ЖОРДАН

Тэрбээр сагсан бөмбөгийн талбайд ялан дийлэгч байсан шигээ бизнесийн салбарт ч амжилт олсоор явна. Майкл тамирчин байх хугацаандаа нийт 93 сая ам.долларын цалин авсан байдаг. Үүний хажуугаар Nike-тай байгуулсан аварга гэрээ нь түүнийг хамгийн баян тамирчдын жагсаалтад жил бүр оруулдаг байв. Улмаар зодог тайлснаас хойш бизнесийн салбарт шилжиж, 2010 онд “Шарлотт Бобкетс” (өнөөгийн “Шарлотт Хорнетс”) багийг 278 сая “ногоон”-оор худалдан авсан юм. Чухам энэ наймаа түүний хөрөнгө зоорийг үлэмж арвижуулсан гэдэг. Майкл багаа зөв менежментээр удирдсаны ачаар 278 сая байсан багийн үнэлгээ нь өдгөө 780

сая болж өсчээ. Энэ өсөлт түүнийг спортоос төрсөн хоёр дахь тэрбумтан болгосон юм. “Форбс” сэтгүүлийн тооцоолсноор түүний Nike-тай хамтарч гаргадаг Air Jordan брэнд нэг тэрбумаар үнэлэгдэж байгаа аж. “Шарлотт” багийнх нь үнэлгээ ч жил ирэх тусам өссөөр байгаа. Энэ жил л гэхэд өмнөх онтой харьцуулахад дөрвөн хувийн өсөлттэй байв. Өдгөө Жорданы нийт хөрөнгө 1.3 тэрбумд хүрчээ.

ФЛОЙД МЕЙВЕДЕР

“Мөнгө” хочит энэ эр мэргэжлийн боксын бүх цаг үеийн түүхэнд дээгүүр байр эзлэх учиртай. Чанга хатуу мэргэжлийн рингэнд 49 тулаан хийж, бүгдэд нь ялалт байгуулсны дараа зодог тайлсан домогт аварга. Улмаар боксоос хоёр жил завсарласны эцэст рингэндээ эргэн ирж, Макгрегорыг зодчихоод 400 саяыг өвөртлөөд харьж байна. Өмнө нь 2015 онд Филиппиний М.Пакьяог ялж, 240 саяыг авсан бол энэ удаа шагналын хэмжээгээ үлэмж өсгөж чаджээ.

Түүнийг сайн боксчин гэдэгтэй хэн ч маргахгүй. Түүнчлэн сайн тулалдахаас гадна мундаг шоучин гэгдээ алхам тутамдаа мэддүүлдэг. Нэг ёсондоо өөрийгөө рекламдаж, үнэд оруулж, олны дунд хүлээлт үүсгэхдээ хамгийн сайн нь. Тиймдээ ч түүний хийсэн тулаануудад асар их боксоо тавигдаж, их мөнгө эргэлдэж байдаг юм. [3ГМ]

Лавлах

БОЛОВСРОЛ 2.6 тэрбум төгрөгийн засвар хийжээ

Б.Баярмаа
ЗГМ

Нийслэлийн хэмжээнд хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангаж, ерөнхий боловсролын 51 сургуульд засвар хийжээ. Үүнд улсын төсвөөс 2.6 тэрбум төгрөг зарцуулсныг албаныхан мэдээллээ.

Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургууль, Сүхбаатар дүүргийн 16 дугаар сургууль, болон Баянзүрх дүүргийн “Шавь” цогцолборт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчныг бий болгосон байна.

Түүнчлэн, Нийслэлийн Засаг даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу сурагчдыг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт 16 сургуулийн гадна талд хурд сааруулагч, замын тэмдэг, тэмдэглэгээ шинээр хийжээ. [ЗГМ]

хөтөч Цахилгааны төлбөрөө шалгуулаарай

Б.Илч
ЗГМ

Цахилгааны төлбөр нь тухайн өрхийн хэрэглээтэй тохирч байгаа, эсэхэд зарим иргэд эргэлздэг. Ийм тохиолдолд цахилгааны хэрэглээ, төлбөрийн зөрүүг олох цөөнгүй арга бий. Тухайлбал, нийслэлийн цахилгаан хэрэглэгчдийн онлайн бүртгэл бүхий myotc.mn сайтад хандаж, цахилгаан хэрэгслийнхээ мэдээллийг оруулж, сарын төлбөрөө ойролцоогоор тооцох боломжтой.

Мөн Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн лавлах утас 7004-7004-т хандаж, мэргэжилтнээр шалгуулж болно. Төлбөрийн бичилт хэрэглээнээс зөрж буй эсэхийг шалгуулахад үнэ төлбөргүй. Харин гэр хорооллын өрхүүдийн шугамаас өөр айл хэрэглэж буйг шалгуулахад 5000 төгрөгийн хураамж авдаг юм байна.

Мөн хэрэглэгчийн долоон оронтой кодоо 137004 дугаарт илгээж төлбөрийн үлдэгдлээ шалгах боломжтой. [ЗГМ]

зөвлөгөө Гар утас нисгэгчийн анхаарал сулруулдаг

Агаарын тээврийн компаниуд нислэгийн үеэр гар утсаа унтраах, эсвэл нислэгийн горимд шилжүүлж ашиглахыг шаарддаг. Нислэгийн үеэр гар утасны сүлжээ унаж, заримдаа агаарын хүчтэй долгионоос болж эвдрэх тохиолдол гардаг. Түүнчлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ч энэ нь ач холбогдолтой. Гэхдээ эдгээр нь гар утсаа нислэгийн горимд шилжүүлэх гол шалтгаан биш юм.

Нислэгийн үеэр гар утсанд хүрэх, оролдох бүрт чимээ нь долгионоор дамжин онгоцны нисгэгч сонсогддог байна. Нисгэгч өндөр чадалтай чихэвч зүүдэг тул ийм долгион тод сонсогдож, анхаарлыг нь сарниулдаг аж. Олон хүн гар утсаа оролдох тусам, нисгэгчийн анхаарал төдий хэрээр суларна гэсэн үг. Нисэх онгоц 9000 метрийн өндөрт гарсан ч гар утас идэвхтэй ажиллаж, сүлжээнд холбогдохоор хайж байдаг аж. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	07.00 “Монголын шинэ өглөө” хөтөлбөр	07.30 “Цахиурын хөндийгөөс цааш” нэвтрүүлэг	07.05 “Монголчууд XX зууны эхэнд” нэвтрүүлэг	09.30 “Тог тог тог” хүүхдийн нэвтрүүлэг
12.00	10.30 “Нутгийн сайхан” нэвтрүүлэг	11.30 “Ажил хэрэгч өглөө” нэвтрүүлэг	11.15 “Харваач” ОАК 2 дугаар бүлэг, 9 дүгээр анги	12.00 “Хөтөч” мэдээллийн хөтөлбөр
14.00	13.20 “Цаг үе, үзэл бодол” (давтал)	15.00 “Бизнесийн төв цэг” хөтөлбөр	14.10 “Шинэ үе” продакшны тоглолт	15.30 “Оёдлын газрын боловсон эрчүүд ОАК 22 дугаар анги
18.00	17.50 “Амьдралын хүрд” уран сайхны кино	17.00 “Bloomberg Surveillance” нэвтрүүлэг	17.10 “Анхдагчид” хүүхэддэйн кино	17.30 “Хүчирхэг рэнжерүүд” хүүхэддэйн кино
20.00	19.00 “Олон нийтийн цаг”	20.30 “Танилц: Япон” нэвтрүүлэг	20.50 “80 саяын уналт” шоу нэвтрүүлэг	20.00 “Оргил цаг” мэдээллийн хөтөлбөр
22.00	21.05 “Нээлтэй хэлэлцүүлэг: Боловсролд хандах нийгмийн ёс зүй”	21.00 “Мөнгөний урсгал” хөтөлбөр	22.10 “Гурван найз” ОАК 5,6 дугаар анги	22.30 “Тэрсүү хөвгүүд” ОАК 5 дугаар бүлэг, 9 дүгээр анги

ОНЦЛОХ ҮЗВЭР

Хоолны фестиваль болно



Шөнийн гэрэлт гудамжинд ирэх сарын 2, 3-нд “UB food festival” арга хэмжээг зохион байгуулна. Энэ үеэр гудамжны хоолны үзүүлбэр, амтлгаат худалдаа болно. Мөн бургер, хотдог, зайрмаг хурдан идэх тэмцээнд оролцох боломжтой. Нийслэлийн аялал жуулчлалын газраас зохион байгуулж буй уг наадамд амьд хөгжмийн Compass хамтлагаас гадна битбок, бүжгийн хамтлагууд оролцох юм. Мөн үлгэрийн баатарын хувцастай шилдэг оролцогчийг тодруулж, шагнах юм байна. Уг арга хэмжээнд үнэ төлбөргүй оролцох боломжтой. [ЗГМ]

ҮЗВЭР

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙ

Чойжин ламын сүм музей Улаанбаатар чуулгатай хамтран “Шөнийн сүм музейд Улаанбаатар чуулга” үдшийн цэнгүүнийг зохион байгуулах гэж байна. Энэхүү арга хэмжээнд хүрэлцэн ирснээр Монголын түүх соёлын үнэт өв Чойжин ламын сүм музейн арвин баялаг сан хөмрөг, хосгүй үнэт бүтээлүүдийг үзэж, мэлмийгээ баясгахын зэрэгцээ Улаанбаатар чуулгын нийт уран бүтээлчид болон Хангарьд найрлын тоглолтыг үзэж, сонирхох боломжтой юм. Тоглолт ирэх сарын 7-ны 21.00 цагт болно.

УДЭТ

Хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцасны үзэсгэлэн худалдаа задгай талбайд ирэх сарын 3-ныг хүртэл үргэлжилнэ.

ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН

Залууст зориулсан “Be... Live show 2017” тоглолтыг ирэх сарын 9-нд хоёр дахь жилдээ зохион байгуулна.

Хичээлийн шинэ жилийн нээлтэд зориулсан шоу тоглолт ирэх сарын 1-нд болно. “Есдүгээр сарын 1” тоглолтод “The Lemons”, “A sound” хамтлагуудаас гадна дуучин Б.Маралжингоо, М.Номин-Эрдэнэ, С.Зоригт, А.Хишигдалай нар оролцоно. Мөн DJ BTB Anna, Muzji зэрэг уран бүтээлчдийн сэтгүүдээс сонсоорой.

UB COMEDY CLUB

Алдартай телевизийн нэвтрүүлгүүдэд өөрийн шог үзүүлбэрээр оролцсон АНУ-ын иргэн Адам Хантер Улаанбаатарын хошин шогийн клубийн тайзнаа тоглоно. Дэлхийн хэмжээний Stand Up тоглолт энэ сарын 31-нд 20.00 цагт болно.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 9

Намрын тэргүүн шар бич сарын гурван хөх мэнгэний шарагчин үхэр өдөр

Үс засуулбал: Өвчин өнүүхэн ирнэ.

Наран ургах, шингэх: 06.12-19.38

Барилдлага: Идэр


Шүтэн барилдлага: Нэр өнгө

Суудал: Уул

Аргын тооллын наймдугаар сарын 30. Буд гараг. Билгийн тооллын 9, Эрхтэний тэнгэрт одтой, шарагчин үхэр өдөр.

Өдрийн наран 06.12 цагт мандаж, 19.38 цагт жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх авах, үнэт эрдэнийн зүйл авах, лус тахих, мал арилжих, гэр бүрээхэд сайн. Цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

- Урлагийн тоглолт явагдах тавцан
- Эмнэлгийн эмчилгээний хэрэгсэл
- Зүс
- Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын хүчит бөхчүүдийн овоглодог гол
- Брезентэй төстэй

материалан хувцас

- Наадамд гурван удаа түрүүлсэн хурдан хүлэг морь
- Улс төрийн ууган нам
- XX зууны тахал гэгдсэн өвчин (товчилсон)
- Гүнзгий нүх, жалга
- Эмнэлгийн ариутгалын бодис

18. Ханш, үнэлгээ

ХӨНДЛӨНГӨӨР:

- БНСЮУ-ын төрийг 35 жил барьсан коммунист удирдагч
- Зүс, царай сайтай
- Уран зохиолын төрөл
- Өөр газар ургуулахаар зөөж бэлдсэн ургамал,

тариа ногооны чих, найлзуур
11. Тун удахгүй
13. Доргоны үр төл
15. Хэлмэгдэж явсан их эрдэмтэн зохиолч
17. Охины нөхөр
19. Сайн ноён хан

Өмнөх дугаарын хариу / 08.29

Б	У	Р	Е	Т	А	Г	Т
В	С	Т	Ө	А			
А	Ө	М	Л				
С	Ө	Н	Ө	Ө	Г	Ч	
Ц	Х	Р		Б			
Ө	Р	Ө	Ө	Б	У	Я	Н
Л		Л	А	Н			
Г	У	Т	Г	А	А	Р	
О	Т	Т	У				
О	У	Я	А	Л			
А	Л	А	Г	Р	О	И	С

ЗГМ: СҮДОКУ


		4		6			3
9	2	5					4
		9	4	8			
5		6					
		9				8	7
2		3		5			
4	6			7			2
				2	8		

8	2	6	3	5	9	1	7	4
9	1	5	8	7	4	3	6	2
7	3	4	6	1	2	5	9	8
1	6	9	2	4	5	8	3	7
3	5	7	9	6	8	2	4	1
2	4	8	7	3	1	9	5	6
5	7	3	1	2	6	4	8	9
4	9	2	5	8	7	6	1	3
6	8	1	4	9	3	7	2	5

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	VIII.30	VIII.31	IX.1	IX.2	IX.3
	22° 7°	22° 9°	21° 10°	16° 10°	19° 9°
Багавтар үүлтэй	9 м/с 6 м/с	8 м/с 6 м/с	7 м/с 5 м/с	7 м/с 6 м/с	7 м/с 5 м/с
		Үүлшинэ	Түр зуурын бороотой	Түр зуурын бороотой	Үүлшинэ



[ЗГМ]

“ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ”
СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА
ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

“ZGM-FINANCIAL TIMES-NYT”
ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС
ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД
5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ
СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ,
СУРВАЛЖЛАГАТАЙ
ХОЛБОотой САНАЛ
ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн ПАЯН...

Пээ ямар балиар амттай эд вэ?

Эмэгтэйчүүд та нар раж ийм юмаар уруулаа буддаг байна?

Наадах чинь хумсны лак шүү дээ Баагий !!!

[ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ]

ГАЛТ ТЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Москва	13.50	14.28
Эрэн-УБ	18.00	11.15
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Хөх хот	20.00	20.49
Хөх хот-УБ	22.50	11.15
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
УБ-Сүхбаатар	21.15	05.12
Сүхбаатар-УБ	20.55	05.03
Сайншанд-УБ	20.25	07.01
УБ-Сайншанд	09.15	19.15

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	17.55	20.10
Бээжин-УБ	21.10	23.40
Сөүл-УБ	14.20	16.50
УБ-Сөүл	08.45	12.50
Токио-УБ	14.40	19.10
УБ-Токио	07.55	13.40
УБ-Хонконг	06.20	10.50
УБ-Франкфурт	10.00	13.00
Франкфурт-УБ	14.30	05.00 +1
Ханбумбат-УБ	19.40	20.45
УБ-Ханбумбат	17.40	18.50

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Пакистан АНУ-ыг орхиж Бээжин рүү хандав

Шинжээчид Трампын Афганистаны бодлого Исламабадыг Бээжинтэй ойртуулах эрсдэлтэйг анхаарууллаа. > 10

Трампын хуульч Кремлээс тусламж хүссэн нь илчлэгдлээ

Трампын байгууллагын ажилтан 2016 онд Москвад байшин барихын тулд Кремлээс дэмжлэг хүссэн нь илэрлээ. > 10

Хятад ажилчид Африкаас буцаж байна

Фужиан мужаас Өмнөд Африк руу цагаачилсан иргэд 350000 хятад иргэдийн гол цөмийг бүрдүүлдэг. > 10

Умард Солонгосын пуужинд Япон түгшүүр зарлав

Бид одоогоор харвасан пуужинд үнэлгээ өгч байгаа” хэмээн Пентагоны төлөөлөгч, хурандаа Роб Маннинг мэдэгдлээ. Уг пуужин Умард Америкт заналхийлээгүйг төлөөлөгч нэмж тайлбарлав.

“Пхеньян 1998 оноос хойш Японы дээгүүр пуужин харваагүй. Энэ удаагийн туршилт нь Умард Солонгосын удирдлага Япон, АНУ-тай сөргөлдөж буйн илрэл” хэмээн Стратеги, олон улсын судалгааны төвийн Умард Солонгос хариуцсан шинжээч Виктор Ча үзэж байна.

Өмнөд Солонгос ч умард хөршийнхөө пуужингийн шинэ туршилтыг буруутгаж, зэмлэв. Умард өдөөн хатгасан үйлдлээ үргэлжлүүлбэл шаардлагатай хариу арга хэмжээ авах тухайгаа Өмнөд мэдэгдлээ. Өмнөд Солонгосын Ерөнхийлөгчийн Хөх ордон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг яаралтай хуралдуулаад байна.

Умард Солонгосын тив хоорондын баллистик пуужин хөөргөх хөдөлгөөнт төхөөрөмжүүд “хэвтээ” байрлалд байгаа ч Пүнгин-ри



Японы өөрийгөө хамгаалах хүчний цэргэ Токиогийн ойролцоох АНУ-ын цэргийн Ёкота базад пуужингаас хамгаалах сургуулиалтад оролцож байгаа нь.

BVM©

цөмийн туршилтын төвд дахин туршилт хийхээр бэлтгэж буйг даваа гарагт Өмнөд Солонгосын тагнуулын алба парламентад мэдэгдсэн.

Түгшүүрт нөхцөлд Өмнөд Солонгосын Гадаад хэргийн дэд сайд Лим Сун-Нам АНУ-ын

Төрийн нарийн бичгийн даргын орлогч Жон Салливантай даваа гарагт уулзаж ярилцлаа. Умард Солонгосын заналхийлэл ихэссэнээс Сөүлийн пуужингийн хүчин чадлыг “аажим, жигд” бэхжүүлэх шаардлагатай болж буйг ноён Салливан уулзалтын

үеэр цохон тэмдэглэсэн юм.

Пхеньян өнгөрсөн долоо хоногт Япон тэнгисийн зүг ойрын зайн гурван пуужин харвасны дараа энэхүү туршилт боллоо. Умард Солонгосын удирдагч Ким Жон Ун АНУ-ыг “Хүндэтгэж эхэллээ” хэмээн Ерөнхийлөгч Дональд

Трамп өгүүлсний дараа пуужин харваж байгаа нь “өдөөн хатгасан үйлдэл” хэмээн Пентагон даваа гарагт мэдэгдэв.

Харвасан пуужингийн хоёр нь “амжилтгүй болсон” хэдий ч Умард Солонгос шинэ туршилт хийх бүртээ алдаагаа засаж буйг

Пентагон анхааруулав. Мягмар гарагт харвасан пуужин нь Пхеньянаас энэ онд харваж буй 18 дахь пуужин. Тус улс нийт таван удаа цөмийн туршилт хийчихээд байгаа. Мөн тив хоорондын баллистик пуужин бүтээх ажил нь “улаан шугам” давах дөхөж байгааг Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Мун Жэ Ин энэ сарын эхээр сануулж байсан юм.

АНУ залхаан цэрлүүлэх шинжтэй эдийн засгийн хориг арга хэмжээ авах замаар Умард Солонгосыг цөмийн түрэмгий хөтөлбөрөөс нь татгалзуулах оролдлогыг олон улсын эвслийн хүрээнд эрэлхийлсээр.

Саяхан Япон, АНУ-ын эзэмшлийн Гуам арлын зүг пуужин харвахаар заналхийлж байсан Умард Солонгосын удирдлага нааштай байр суурь баримтлах төлөв бага байгааг дипломатууд анхааруулдаг. АНУ 17500 цэргээ оролцуулсан өргөн цар хүрээтэй цэргийн сургуулиалтыг Өмнөд Солонгостой хамтран энэ сард хийсэн нь байдлыг хурцатгана хэмээн албаны хүмүүс түгшиж байв. Гэхдээ хариуд нь Умард Солонгосын эрх баригчид Японы дээгүүр пуужин харвана хэмээн таамагласан шинжээч цөөн байлаа.

Умард Солонгосын эдийн засгийн гол түнш Хятад, уламжлалт дипломат холбоотон ОХУ хоёр ч энэхүү зожиг улсын зэр зэвсгийн туршилтыг болиулахад хувь нэмрээ оруулах ёстой хэмээн АНУ үздэг.

FT

Гялгар уут хэрэглэвэл дөрвөн жилийн ял онооно



Шинэ хууль нь хэрэглэгч, жижиглэн худалдаачдад бус үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчдэд чиглэж байна.

BVM©

Жон Аглионби
Африкийн Кени улс хуванцар хог хаягдлыг бууруулах зорилготой дэлхийн хамгийн хатуу хуулийг даваа гарагаас мөрдөж эхэллээ. Одооноос эхлэн тус улсад нийлэг уут борлуулах, хэрэглэсэн хүмүүс дөрвөн жил хүртэлх хугацаагаар шоронд ял эдлэх, эсвэл дөрвөн сая кени шиллингээр (38 мянган ам.доллар) торгуулна.

Дорнод Африкт эдийн засгаар тэргүүлдэг тус улсад нийлэг уут ашиглах, үйлдвэрлэх, импортоор оруулахыг хориглоод байна. Шинэ хууль гол нь үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч нарт чиглэж байгааг Кенийн Байгаль орчны сайд Жуди Вакунгу тайлбарлав. “Олон нийт шинэ журамд дасах хэрэгтэй болох нь. Хүмүүс сурсан зангаа орхиход хугацаа орж таарна” хэмээн тэрбээр өгүүлж байлаа.

Кенид жил бүр 300 сая ширхэг нийлэг уутыг хэрэглэн буй орчинд халтай байдлаар хаядаг. Эдгээр уут байгальд эргэн шингэхэд хэдэн зуун жил шаардагдахаар байгааг тус улсын Засгийн газар тайлбарласан юм.

Кенийн хүрээлэн буй орчны менежментийн агентлаг (NEMA) шинэ хориг үйлчилж эхэлснийг даваа гарагт мессеж ашиглан иргэдэд анхаарууллаа. Тус агентлаг нийлэг уутны хэрэглээг илрүүлэх зорилгоор хэрэглэгчдийг нэгжих, үйл

ажиллагааг нь таслан зогсоох эрх эдэлнэ. Гаалийн татваргүй барааны дэлгүүрт наймаа хийсэн гаднын жуулчид нийлэг уутыг нь нисэх буудалд үлдээх ёстой.

Хаягдаж буй төрөл бүрийн нийлэг уут, хуванцар савнаас шалтгаалан тэжээмэл мал сүргээс халим хүртэлх бүх адгуус амьтны биед хуванцар агуулга ихэссээр байгаа нь хүмүүсийг түгшээх боллоо. БНХАУ, Руанда, Франц зэрэг дэлхийн 40 гаруй улс нийлэг уутны хэрэглээг хориглох, татвар тогтоох аргаар асуудлыг шийдвэрлэхээр хичээж байна.

“Ийм арга хэмжээ үр дүнгээ өгөх юм бол манай гарагт асар их уршиг тарьж буй хуванцар бохирдлыг багасгахад эргэлт гарна” хэмээн Найроби дахь НҮБ-ын хүрээлэн буй орчны агентлагийн тэргүүн Эрик Солейм тайлбарлав.

Тодорхой цөөн тохиолдолд, жишээ нь, бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрт баглах, мөн хог хаягдал хадгалах зориулалттай нийлэг уут ашиглахыг тусад нь зөвшөөрөөд байна.

Хуванцар үйлдвэрлэлийн салбарын эсэргүүцлийг үл хайхран уг хуулийг Кенийн эрх баригчид хэрэгжүүлээ. Хориг хэрэгжиж эхлэх хугацааг хойшлуулахаар Кенийн үйлдвэрлэгчдийн холбоо заргалдсан ч амжилтгүй болж, шинэ хууль олон арван мянган ажлын байрыг үгүй хийж, хөрөнгө оруулагчдыг “үргээх”

аюултайг анхаарууллаа.

“Кени даяар төрөл бүрийн хуванцар бүтээгдэхүүний 176 үйлдвэрт тус улсын нийт ажиллах хүчний 2.89 хувь нь ажилладаг. Үүн дээр шууд бусаар ажилладаг 60 гаруй мянган хүн нэмэгдэнэ. Хоригоос болоод энэ олон хүний амьдрал хэцүүднэ” хэмээн тус холбоо мэдэгдэв.

Хуванцар хаягдал нь “Хог хаягдлын менежмент, хэрэглэгчдийн дадал заншлыг өөрчлөхтэй холбоотой болохоос биш үйлдвэрлэлтэй холбогдох учиргүй” хэмээн тус холбоо тайлбарлаж байна.

Харин сайд Вакунгу хориг нь бизнес төрөлжин хөгжих, байгаль орчинд ээлтэй, дахин ашигладаг уут савны хэрэглээ үүсгэх боломж бүрдүүлэх тул шинэ шинэ ажлын байр үүснэ хэмээн хариуллаа. Кенийн том хотуудын гудамжинд дахин ашигладаг шинэ төрлийн уут, сав борлуулагчид хэдийнэ гарч ирээд байна.

Харин Найроби хотын бизнесийн дүүрэгт гурван ч том нийлэг ууттай ногоо бүхий Мэри Мвориа сурсан зангаа гэхэд хэцүү байгаагаа өгүүллээ. “Төв зах дээр ногоо зарахдаа өдөрт 30 гаруй гялгар уут ашигладаг. Шинэ журамд нийтээр дастлаа хэдэн сар болох байх. Уг нь зөв гэдгийг мэдэж байна. Гэхдээ бидний хувьд дандаа зөв юм хийх хэцүү” хэмээн ярих.

FT

Panasonic
nanoe
АГААР ЦЭВЭРШҮҮЛЭГЧ

Харшил үүсгэгчдийг 99% УСТГАНА.

Их Британийн Харшил Судлалын сангаас Panasonic агаар цэвэршүүлэгч нь харшил хөдөлгөгч, үүсгэгчдийг бусдаас илүү багасгаж, агаарыг цэвэршүүлдгийг баталсан сертификат болон “Батламж”-ийг олгов.

ХАРШИЛ ХӨДӨЛГӨГЧИЙГ ХАШРААГЧ
Super aliera-buster
Фенол полимерийн тусламжтайгаар тодорхой харшил үүсгэгчдийг 99% устгана.

НОГООН ЦАЙТАЙ КАТЕХИН
Green Tea Catechin
Ногоон цайтай катехины тусламжтайгаар тодорхой вирусуудыг 99% устгана.

БАКТЕРИЙН ЭСРЭГ ЭНЗИМ
Anti-bacteria Enzyme
Бактерийн эсрэг энзим нь бактер болон хөгцийг нөхөн үржихээс сэргийлж, орчныг цэвэршүүлнэ.

Утас: 7722-0272
www.bsb.mn

Better Lifestyle **BSB**

Фархан Бохари, Юан Ян

Шинжээчид Ерөнхийлөгч Дональд Трампын Афганистаны талаар баримталж буй бодлого Исламабадыг Бээжинтэй ойртуулах эрсдэлтэйг анхаарууллаа. Мөн Пакистан Вашингтоны өндөр албаныхантай хийх байсан гурван чухал уулзалтыг цуцлахад нөлөөлөв. Төрийн нарийн бичгийн даргын туслахын үүрэг гүйцэтгэгч Алис Уэллс Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажилтан Лиза Куртис нар энэ долоо хоногт Пакистанд ирж, бүс нутгийн асуудлаар Вашингтоны шинэ бодлогыг тайлбарлах ёстой байв. Гэвч Исламабад хоёр уулзалтыг тодорхойгүй хугацаагаар цуцалж, Пакистаны Гадаад хэргийн сайд Хаважа Асифын АНУ-д хийхээр төлөвлөсөн айлчлалаас татгалзсан байна. Өнгөрсөн долоо хоногт ноён Трамп Афганистанд цэргээ үлдээх тухайгаа ярихдаа алан хядагчдыг орогнуулж байна хэмээн Пакистаныг буруутгасан юм.

АНУ-ын Төрийн департамент даваа гарагийн өглөө хатагтай Куртисын гурван оронд хийх айлчлалын нэг нь Пакистан гэж мэдэгдсэн боловч дараа нь цуцлагдсаныг мэдээд Төрийн департаментын хэвлэлийн төлөөлөгч “Пакистаны Засгийн газрын хүсэлтээр айлчлалыг харилцан тохиромжтой цаг үе хүртэл хойшлуулсан” гэв. Ноён Трамп Пакистаныг хил дамнасан алан хядагчдыг зогсоохын тулд илүү зүйл хийх шаардлагатай гээд “Тус улс манай иргэдийг өдөр бүр хөнөөхийг оролддог байгууллагыг орогнуулж байна” хэмээн шүүмжилсэн.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон



Өнгөрсөн долоо хоногт ноён Трамп Афганистанд цэргээ үлдээх талаар ярихдаа алан хядагчдыг орогнуулж байна хэмээн Пакистаныг буруутгасан юм.

Пакистан АНУ-ыг орхиж Бээжин рүү хандав

хоёр улсын итгэлцэл суларч буйг тэмдэглээд Пакистанд үзүүлэх Америкийн дэмжлэг тэднийг хандлага сонгох эсэхээс шалтгаална гэжээ. Пакистаны Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Шахид Абаси хэвлэлд ярихдаа “Эхний өдрөөс л бид Афганистан дахь цэргийн стратеги амжилтад хүрсэнгүй, цаашид ажиллах боломжгүй гэдгийг тодорхой сануулсан” гэв. Гэвч шинжээчид

Америкийн бодлого Пакистаныг Бээжин рүү түлхэх байх хэмээн анхаарууллаа. Хятад улс шинэ торгоны зам бүтээх “Нэг бүс нэг зам” төслийн хүрээнд өмнөд хөршдөө 50 тэрбум ам.долларын хөрөнгө оруулаад буй.

Ноён Асиф АНУ-д айлчлахын оронд Хятад, Турк, Орост очихоо зарласан байна. Пакистаны ГХЯ-ны өндөр тушаалын нэгэн ажилтан манай сонинд

ярихдаа “Ерөнхийлөгч Трамп Афганы дайныг Пакистан руу шилжүүлэхээр заналхийлж буй энэ цаг үед Хятад улс бидэнтэй хамт байгаа. Бид цаашид Вашингтонтой хэлэлцээрээ үргэлжлүүлж, хоёр талын харилцааг хэрхэн үр ашигтай болгох талаар ярилцана” гэсэн байна. Пакистан улс хүйтэн дайнаас хойш АНУ-ын чухал холбоотон байсаар ирсэн агаад Зөвлөлтийг эсэргүүцсэн

можахедын дайнд тусалж байсан юм.

Гэвч тэр үеэс хойш харилцаанд нь ан цав гарчээ. Вашингтон тус улсыг Афганистанд хүрэх гүүр болгохын зэрэгцээ довтоодын терроризмыг хазаарлах чадваргүйг нь шүүмжилдэг юм. Сүүлийн жилүүдэд Пакистан газар нутгаа АНУ-ын хангамжийг Афганистанд хүргэхэд ашиглуулж ирсэн

бөгөөд өөрөө Америкийн дроны дайралтад өртөж байв. Хариуд нь олон зуун сая ам.долларын цэргийн тусламж авч байсан боловч нутагтаа Талибан гэх мэтийн босогчдыг дарж чадаагүй тул тусламжийн үлэмж хэсгийг цуцалсан билээ.

Үүний хажуугаар Исламабад Хятадын зөөлөн нөхцөлтэй зээл, гадаад валютын дэмжлэгээс улам бүр хамааралтай болж байна. 2016 оноос хойш Хятад улс Пакистанд тэрбум гаруй ам.долларын зээл олгож, гадаад валютын хямралаас аварч байв. Карачи дахь төв банкны ажилтан “Төлбөрийн тэнцэл алдагдахаас сэргийлэхэд Хятадын оролцоо ихээхэн тустай” гэжээ.

Бээжингийн хувьд энэ харилцаа Хятадын баруун бүсийн Шинжааны бизнес шинэ орон зай нээхийн хамт Энэтхэгтэй муудсан харилцаанд холбоотон олоход тусална. Хятадын олон улсын судалгааны хүрээлэнгийн Ойрх Дорнодын хэлтсийн дарга Ли Гуофу “Өмнөд Азийн талаарх Трампын шинэ бодлого хэрэгжиж эхлэхээс өмнө Пакистанд аюул занал хийлэл үүсгэж, сөрөг хариу өгөхөд хүргэлээ... Хятад улс энэ нөхцөл байдалд идэвхтэй туслахыг хичээсээр ирсэн” хэмээв.

Гэхдээ Пакистан Хятадтай ойртохыг эрмэлзэж байгаа ч АНУ-тай харилцаагаа бүрэн таслахгүй гэж ажиглагчид дүгнэсэн байна. Вашингтонд Пакистаны Элчин сайдаар сууж байсан Наммуддин Шейх “Дипломат харилцаанд, ялангуяа Пакистан, Америкийнх шиг эртний харилцаанд эрүүл дүн шинжилгээ хийж, яриа хэлэлцэнээс татгалзахгүй байх нь чухал” хэмээн анхааруулжээ. **FT**



Трампын хуульч Кремлээс тусламж хүссэн нь илчлэгдлээ

Деметри Севастополю

Трампын байгууллагын дээд тушаалын ажилтан 2016 онд Москвад байшин барихын тулд Кремлээс дэмжлэг хүссэн нь илэрхий боллоо. Энэхүү илчлэлт сунгааныхаа үеэр баг нь нэг ч хүн Оросын Засгийн газартай холбоогүй хэмээн мэдэгдэж байсан Трампын үгийг үнэгүйдүүлэв. Trump корпорацийн хуучин зүтгэлтэн, Ерөнхийлөгчийн хувийн өмгөөлөгч Майкл Коэн 2016 оны нэгдүгээр сард Кремлийн хэвлэлийн төлөөлөгч Дмитрий Песковт цахим шуудан илгээж, тусламж хүссэнийг даваа гарагт Конгресст танилцуулсан баримтад дурдсаныг Washington Post сонин мэдээлэв.

Ноён Коэн бичсэн захидалдаа “Өнгөрсөн хэдэн сард би Оросын компанитай Москва хотод Трампын цамаг босгох талаар ажиллалаа. Нарийвчлан дурдалгүйгээр хэлэхэд, манай хоёр талын хэлэлцээ зогссон. Энэ төсөл маш чухал тул би үүгээр танаас тусламж эрж байна. Хэн нэгэн, та бол бүр сайн, надтай холбогдож уг асуудлыг хэлэлцэх ба зохих хүмүүстэй уулзалт зохион байгуулахыг хүндэтгэлтэйгээр хүсэж байна” хэмээн өгүүлжээ.

Хэдийгээр ноён Коэн Трампын сурталчилгааны багийн албан ёсны гишүүн байгаагүй боловч зурагтаар үг хэлж, нэр дэвшигчийг улс төрийн дайралтаас хамгаалж байсан. Түүнчлэн БНН Трампыг албан ёсоор нэр дэвшигчээр зарлах ёслолд байлцсан юм. Ноён Путины хэвлэлийн төлөөлөгч Песковт илгээсэн Коэны Мэйл нь Трампын баг ба Москвагийн хэлхээ холбооны хамгийн бодитой нотолгоо боллоо. Financial Times сонин Кознтэй холбогдож Мэйлийн талаар асуухад Трампын байгууллага сүүлийн 40 жилд үл хөдлөхийн олон төсөл авсанд гайхаад байх зүйлгүй гэж хариулсан юм.

Ноён Коэн энэ талаарх мэдэгдэлдээ “Трампын Москвад өгсөн санал тус байгууллагын барилгын олон саналуудын нэг л байсан. Үүнийг хэлэлцээд эцэстээ татгалзсан. 2016 оны нэгдүгээр сарын сүүлээр би төслийг хэрэгжүүлэх үл хөдлөхийн лиценз, санхүүжилт, засаг захиргааны зөвшөөрөл авах итгэлээ алдсан учир уг саналыг орхисон. Энэ бол амжилтад хүрээгүй барилгын санал, илүү зүйлгүй” гэжээ.

Энэ Мэйл Трампыг сонгогдоноос хойш мөрдөж буй

Оростой холбоотой гэх шуугианы сүүлийн баримт юм. Холбооны мөрдөх товчооны захирал асан Роберт Мюллер Трампын сурталчилгаа болон Кремлийн хэлхээ холбоог мөрдөн байцаах Шүүх яамны хэсгийг ахалж буй. Ерөнхийлөгч уг мөрдөн байцаалтыг удаа дараа шүүмжилж, Хиллари Клинтон мөрдөн байцаах Шүүх яамны Ардчилсан намынхны явуулгаар шулмын ангуучлал хийж байна хэмээн буруутгаж байна.

Гэвч тэрбээр өөрөө Оросыг шүүмжлэхээс түдгэлзэж байгаа болон түүний хүү залуу Трамп, хүргэн Жаред Кушнер нарын Оростой харилцсан тухай өмнө нь мэдэгдээгүй баримтууд илэрсний улмаас уг асуудал бүрч анхаарал татлаа. Даваа гарагт ноён Трамп Финландын Ерөнхийлөгч Саули Ниинистотой хамтарсан хэвлэлийн бага хурал дээр АНУ эцсийн эцэст сайн харилцаа тогтооно гэдэгт найдаж буйгаа илэрхийлжээ. Тэрбээр “Хэзээ нэгэн цагт сайн харилцаа авах итгэлээ алдсан учир уг саналыг орхисон. Энэ бол амжилтад хүрээгүй барилгын санал, илүү зүйлгүй” гэжээ. **FT**

Хятад ажилчид Африкаас буцаж байна

Том Ханкок

Хятадын зүүн өмнөд эрэг дэх загасчдын нойрмог тосгоны хэдэн арван оршин суугчдын адилаар Вен Веноан хэдэн жилийн өмнө шинэ амьдрал эхлүүлэхээр Африкийг зорьжээ. Гэвч тэрбээр энэ жил эх орондоо буцахаар шийдсэн аж. Вен хувийн ба улсын компанид ажиллаж байгаад таваарын үнийн уналтад өртсөн Африкийн орнуудаас буцаж ирсэн хэдэн зуу мянган хятад ажилчдын нэг юм. 2016 онд Сахараас урагш Африкийн өсөлт 1.5 хувь руу унасан нь 20 жилийн доод үзүүлэлт агаад Өмнөд Африкт хүртэл энэ жилээс эдийн засаг нь буурч эхэллээ. Иоханнесбург хот орчимд таван жилийн турш супермаркет ажиллуулж байсан 33 настай Вен “Эдийн засаг муудсанаас бид эргэж ирсэн” хэмээн ярьж байв.

судалж буй Барри Саутман “Тивийг бүхэлд нь авч үзвэл цөөрсөн. Зарим талаар таваарын хэлбэлзлийн мөчлөгтэй холбоотой боловч хятадууд бизнес эрхлэхэд ашиг муутай болж байна” гэж дүгнэв. Цагаачдын тоо буурч байгаа нь Хятад, Африкийн худалдаа, хөрөнгө оруулалт хумигдаж буйг харуулж байна. 2015 онд 200 тэрбум ам.долларт хүрч байсан хоёр талын худалдаа өнгөрсөн онд 150 тэрбум руу урууджээ. Худалдаатай харьцуулахад Африк дахь Хятадын шууд хөрөнгө оруулалт үл тооцохуйц бага хэмжээтэй аж.

Бизнесийн соёл, цагаачлалын түүх арвинтай Фужиан мужаас 2000-аад оны эхээр Өмнөд Африк руу хэдэн зуун мянгаараа цагаачилсан иргэд 350000 хятад иргэдийн гол цөмийг бүрдүүлдэг. Фужиан мужийн бөглүү тосгонд

Хятадад хөдөлмөрийн хөлс нэмэгдэж байгаа нь мэргэжилтэй ажилчид цагаачлахаас татгалзах нэг хүчин зүйл юм. Гэхдээ ерөнхий хандлагаас ялгаатай жишээ бий. Зүүн Африкийн Этиоп, Кени улсуудад Хятадын цагаачдын тоо нэмэгдэж байгаа аж. Энэ бүс Бээжингийн “Зам ба бүс” дэд бүтцийн төсөлд хамрагдсан тул энд Хятадын талаас үйлдвэрлэл, тариалангийн хөрөнгө оруулалт нэмэгджээ. Хятадын Ерөнхийлөгч Шин Жиньпин 2015 онд хэлэхдээ, Африкийн төслүүдэд ирэх гурван жилд 60 тэрбум ам.доллар зарцуулна гэж мэдэгдэж байсан билээ.

Бээжингийн их сургуулийн Африкийн харилцааны шинжээч Лиу Хайфан “Шинэ чиглэл эхэлсэн. Африкийг зорьж буй хүмүүс худалдаачид, ажилчид бус Хятадтай аж үйлдвэрийн нягт



Африк дахь Хятадын улсын үйлдвэрийн ажилчдын тоо 32 мянгаар цөөрч, 233000 болсныг Хятадын олон улсын гэрээт ажилчдын холбоо мэдээлжээ.

Шинжээчдийн үнэлгээнээс үзэхэд 2013 онд нэг сая хүрч байсан Африк дахь хятад иргэдийн тоо буурч, нефтээр баялаг Анголоос л гэхэд сүүлийн дөрвөн жилд 150000 орчим хятад ажилчин нутагтаа буцжээ. Африк руу цагаачилсан тус улсын иргэдийн дунд жижиг бизнесменүүд зонхилдог авч өнгөрсөн онд Хятадын улсын үйлдвэрийн ажилчдын тоо 32 мянгаар цөөрч, 233000 болсныг Хятадын олон улсын гэрээт ажилчдын холбоо мэдээлжээ.

Хонконгийн Шинжлэх ухаан, технологийн их сургуульд Хятадаас Африк руу цагаачлалыг

очсон гийчид зам асуухад Өмнөд Африк аялгуутай англи хэлээр хариулт өгөх нь элбэг. Цагаачлал элдгээр тосгодын нүүр царайг өөрчилж, олон айлын үүдэн хэрээ зурсан үзэгдэх агаад тус мужид христийн шашинтан олширсныг илтгэнэ.

Гэвч буцаж ирэгсдийн гомдоллосон яриа залуусыг Африк руу явахаас түдгэлзүүлж байгааг ноён Саутман дурдаад “Буцаж ирсэн хүн бүр өөрийн түүхтэй. Тэр нь голдуу сөрөг хандлагатай байдаг. Зарим нь эдийн засгийн, зарим нь улс төр, соёлын шалтгаантай. Энэ бүхэн нөлөөлж байна” гэжээ. Түүнчлэн харилцаатай улсуудад бизнес үйлчилгээ эрхлэгчид байх болно” хэмээв. Фужианы эрэг хавийн тосгодын оршин суугчид Хятадад орон сууцны үнэ өссөнийг дагаад хуримын инжний хэмжээ сая юань хүрсэн тул цагаачлахыг хүсдэг залуус олон бий гэж ярьсан юм. Харин сүүлийн үед залуус Өмнөд Америкийг зорих нь олширч байна. Тосгоны иргэн Чен Даочун залуус Аргентин, Бразилд азаа туршихыг эрмэлзэх болсныг дурдаад “Манай садангууд дэлхийгээр тарж байна. Эхнэр олохын тулд маш их мөнгө шаардлагатай” хэмээн өгүүллээ. **FT**

Эдийн засаг

УУЛ УУРХАЙ

Тусгай зөвшөөрөл тойрсон авлигын 14 эрсдэл байна

Ашиглалтын тусгай зөвшөөрөл олголтод авлигын эрсдэл илрээгүй

Г.Байгал
ЗГМ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход авлигад өртөж болзошгүй 14 эрсдэл байгааг “Транспэрэнси Интернэшнл” байгууллага мэдээллээ. Дэлхий даяар 100 гаруй салбартай энэ байгууллага Монгол Улсын уул уурхайн авлигын эрсдэлийг үнэлсэн байна. Эхний ээлжинд тусгай зөвшөөрөл олгоход хээл, хахууль авч болон өгч болзошгүй 89 сул тал байгааг тогтоож, эдгээрт үндэслэн авлигын 14 эрсдэл байгааг тодорхойлсон байна.

Тухайлбал, хайгуулын тусгай зөвшөөрлийг дийлэнхдээ өргөдлөөр олгодог. Ингэснээр хэн гүүрүүлж хүсэлт гаргасан нь тусгай зөвшөөрөл авдаг. Гэхдээ энэ үйл явцад авлигад өртөх эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл, өргөдөл гаргагчийн бүртгэлийн дэс дарааллыг солих, өргөдөл дэх мэдээллийг өөрчлөх боломжтой. Тиймээс эдгээр сул тал нь авлигыг өдөөх эрсдэл болдог байна.

Үүнээс гадна хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг орон нутгийн засаг захиргаа дэмжсэн тохиолдолд олгодог. Тэгвэл орон нутгийн засаг захиргаа хуульзүйн үндэслэлгүй татгалзах, нутгийн удирдлагын шийдвэр гаргах чадвар дутмаг байх сул тал ажиглагдсан байна. Эдгээр ч мөн авлигын суурь болдог байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрөл олголтод авлигын эрсдэл илрээгүй болохыг “Транспэрэнси Интернэшнл” байгууллага мэдээллээ.

Уул уурхайн компани болон орон нутгийн захиргаа хамтран



С.Батсайхан / ЗГМФ

ажиллах гэрээ байгуулахад авлига авах эрсдэл бий. Уг гэрээгээр орон нутаг болон компани үүрэг, хариуцлагаа тодорхойлдог.

ТЭЗҮ баталж, тусгай зөвшөөрөл олгосныхоо хариуд авлига авах боломж нээгддэг

Гэвч гэрээ хэт ерөнхий, зүйл заалтынх нь хамрах хүрээ тодорхой бус бол тус баримт бичгийг гуйвуулан шийдвэр гаргагчид болон компаниуд ашиг хонжоо олох боломжтой. Гэрээг байгуулахад орон нут-

гийн иргэдийн дуу хоолойг сонсодоггүй. Зөвхөн орон нутгийн засаг дарга болон компани харилцан тохиролцдог. Энэ нь авлигын бараан сүүдэр тусах магадлалыг нэмэгдүүлж буй.

Тэрчлэн Монгол Улсын Засгийн газар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо тухайн компанийн ТЭЗҮ-ийг шалгадаг. Харин тусгай зөвшөөрлийг бусад шилжүүлэх, сонгон шалгаруулалтаар олгоход шаардлагын хянан, магадлал нь сулардаг байна. Тиймээс ТЭЗҮ баталж, тусгай зөвшөөрөл олгосныхоо хариуд авлига авах боломж нээгддэг гэсэн үг.

Монгол Улсад хайгуул хийлгүй дамлан худалдах зорилгоор хайгуулын тусгай зөвшөөрөл цуглуулах тохиолдол цөөнгүй байгаа нь илэрчээ. Энэ төрлийн дамлагчид нь авлигын чанартай үйл ажиллагаанд оролцоход бэлэн

● **Тусгай зөвшөөрөл олгоход хээл, хахууль авч болон өгч болзошгүй 89 сул тал байгааг тогтоожээ**

● **Тусгай зөвшөөрлийг бусад шилжүүлэх, сонгон шалгаруулалтаар олгоход шаардлагын хяналт сулардаг байна.**

● **Хараат бус үнэлгээ нь бизнесийн салбар, хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудад ч ач холбогдолтой.**

байдаг. Тусгай зөвшөөрөл дамлах нь хавтгайрвал уул уурхайн салбарын хөгжлийг удаашруулж, авлига цэцэглэхэд нөлөөлдөг. Энэ мэт тусгай зөвшөөрөл тойрсон эрсдэлүүдийг “Транспэрэнси Интернэшнл” байгууллага тогтоожээ.

Энэ хараат бус үнэлгээ нь зөвхөн уул уурхайн салбарын ил тод хариуцлагатай байдлаас гадна бизнесийн бусад салбар, хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудад ч ач холбогдолтой болохыг “Транспэрэнси Интернэшнл Монгол” байгууллагын гүйцэтгэх захирал О.Батбаяр хэлсэн юм. “Транспэрэнси Интернэшнл” байгууллага “Тогтвортой хөгжлийн төлөөх уул уурхай” олон улсын хөтөлбөрийн хүрээнд 20 улсад энэ үнэлгээг зэрэг хийж байгаа. Монгол Улс хамгийн түрүүнд үнэлгээг танилцуулж буй нь энэ. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **БАНК САНХҮҮ**

36

Ханш. Төгрөгийн гадаад валюттай харьцах албан ханшийн мэдээллийг ТҮЦ машинаас авах боломжтой боллоо. Энэ лавлагаа нь дэлхийн 36 улсын валютын төгрөгтэй харьцах тухайн өдөр болон улирлын дундаж ханш, алт, мөнгө худалдан авах үнийн мэдээллийг багтаажээ.

» **ТҮҮХИЙ ЭД**

0.5

Хувь. West Texas төрлийн газрын тосны ханш 0.5 хувиар өсөж, баррель нь 46.82 ам.долларт хүрлээ.

» **ЭКСПОРТ**

5000

“Дархан нэхий” ХК европын зах зээлд 5000 ширхэг арьс нийлүүлжээ. Мөн дэвсгэр хийх зориулалттай үстэй боловсруулсан хонины нэхий, ямааны арьс, сарлагийн ширийг Голланд руу экспорлож эхэлжээ.

» **АШИГ**

40

Хувь. Газрын тос боловсруулалтаар дэлхийд тэргүүлэгч “Sinorec” компанийн хагас жилийн ашиг 40 хувиар өссөн байна.

ВАЛҮТЫН ХАНШ

Ам.доллар	2433.65
Евро	2931.94
Япон иен	22.43
ОХУ рубль	41.54
БНХАУ юань	368.75
БНСУ вон	2.16

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөрөнгө оруулагчдын гомдлыг хянах журам боловсруулсан

Г.Илч
ЗГМ



Ж.Мөнхбат гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, аж ахуйн нэгжүүд ч ашигтай ажиллаж эхэлснийг онцолсон юм. Өнгөрсөн онд Дэлхийн банк групп гадаад, дотоодын 33 аж ахуйн нэгж дунд судалгаа явуулахад төрийн байгууллагууд гомдлыг шийдвэрлэх, түүнийг хэрэгжүүлэхдээ маш тааруу гэсэн үнэлгээ авсан байна. Гомдолтой холбогдон 1.9 тэрбум

ам.долларын хөрөнгө оруулалт эрсдэлтэйд тооцогджээ. Иймээс Засгийн газрын дэргэдэх Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл эрх зүйн орчны илүү таатай болгохоор “Хөрөнгө оруулагчаас төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын төсөл боловсруулсан тухай арга хэмжээний үеэр мэдээлэв. [ЗГМ]

УУЛ УУРХАЙ

ММС-гийн орлого найм дахин өсчээ

Т.Элиса
Шинжээч

Хонгконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Mongolian Mining Corporation” энэ оны эхний хагас жилд 245.9 сая ам.долларын орлого олжээ. Энэ нь жилийн өмнөхөөс ойролцоогоор найм дахин өссөн дүн. Тус компани 2.3 сая тонн нүүрс борлуулсан нь жилийн өмнөхөөс дөрөв дахин өндөр үзүүлэлт. Угаасан коксжих нүүрсний дундаж ханш

тонн тутамдаа 127.7 ам.доллар болсон нь жилийн өмнөхөөс 145 орчим хувиар нэмэгдсэн талаар “Mongolian Mining Corporation” санхүүгийн тайландаа дурджээ. Оны эхний хагас жилд дээрх компани өрийн бүтцийн шинэчлэлээ гүйцэтгэж, тавдугаар сард эцэслэсэн юм. “Зах зээлийн өмнөхөөс ойролцоогоор найм дахин өссөн дүн. Тус компани 2.3 сая тонн нүүрс борлуулсан нь жилийн өмнөхөөс дөрөв дахин өндөр үзүүлэлт. Угаасан коксжих нүүрсний дундаж ханш

логистикийн үр өгөөжтэй байдлаа сайжруулсаар байх болно” гэж “Mongolian Mining Corporation”-ийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэл онцолж байна.

Энэхүү мэдээлэл гарахтай зэрэгцээд Хонгконгийн хөрөнгийн биржид “Mongolian Mining Corporation”-ийн хувьцааны ханш буурсан байна. Сүүлийн зургаан сард тус компанийн хувьцааны ханш огцом суларсан боловч дахин сэргэж, хагас жилд дундаж 1.61 хувиар өссөн байна.

Санхүү эдийн засгийн их сургууль МЕНЕЖМЕНТИЙН УХААН, БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТӨӨ УРЬЖ БАЙНА

БҮРТГЭЛ: 2017.08.25-2017.09.10



ДАРААХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ УРЬЖ БАЙНА.

✓ Бизнесийн удирдлага, менежментийн чиглэлээр эрдмийн ажил хийж буй **СУДЛААЧ, БАГШ НАР**

✓ Бизнесийн салбарт мэргэжлийн өндөр түвшинд манлайлан ажиллаж, судалгаанд суурилсан үндэслэлтэй шийдвэр гаргах мэдлэг, чадвар эзэмшихийг хүсч буй **УДИРДАХ** түвшний болон мэргэжлийн өндөр мэдлэгтэй **АЖИЛТНУУД**

✓ Бизнесийн зөвлөх үйлчилгээг өндөр түвшинд үзүүлэхээр зорьж буй **ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТНҮҮД**

ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОГ:

• Орчин цагийн бизнес, менежментийн ухааны онол, практикийн асуудлыг шинжлэх ухааны салбаруудын уулзварт холбон авч үзэж, салбар дундын асуудлыг шийдвэрлэхийг зорих

• Элсэгчид бэлтгэл үе шатанд СЭЗИС-ийн төсөлт судалгааны багт ажиллан судалгаа хийх аргагүй, ур чадвараа хөгжүүлнэ. Багийн хэрэгжүүлэх судалгааны төсөлт ажлыг СЭЗИС санхүүжүүлнэ

• Гадаад, дотоодын профессор багш нар судалгааны ажилд зөвлөх

Утас: 7000 8085, 9901 6918
Web: www.ufe.edu.mn/phd/

Эдийн засаг

Азийн хувьцаануудын ханш уналдаа



БНАСАУ мягмар гарагт Японы дээгүүр баллистик пуужин хар-васнаас үүдэн Азийн хөрөнгийн зах зээл уруудлаа. БНСУ-ын Kospi индекс 1.2 хувиар буурсан бол Австралийн ASX 200 индекс 0.9 хувиар доошлов. Мөн Японы Торих индекс 0.3, Хонконгийн Hang Seng 0.4 хувиар тус тус багасчээ. Харин Хятадын хөрөнгийн зах зээлийн жишиг

Shanghai Composite индекс 0.2 хувиар өссөн байна. Ийнхүү бүс нутгийн хөрөнгийн зах зээлд уналт давамгайлж буйтай зэрэгцээд алтны ханш чангарч эхэллээ. Олон улсын зах зээлд шар металлын ханш мягмар гарагт 0.7 хувиар буурч, 1317 ам.долларт хүрлээ. Тус металлын үнэ даваа гарагт 1.3 хувиар өссөн юм. [ЗГМ]

Microsoft МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР АМЖИЛТЫН ҮНДЭС

Microsoft Dynamics NAV ERP системийг Монголд

INTER SOLUTIONS MANAGEMENT LLC
УТАС: +976 76009293
support@ism.mn

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	66.6	▲ 0.15%	8/29/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.017	▲ 13.33%	8/29/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	11.5	▼ -6.06%	8/29/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.019	▲ 5.26%	8/29/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	8/29/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.5	▲ 5.42%	8/29/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.04	▲ 4.39%	8/29/2017
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.22	▼ -4.35%	8/29/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.185	▼ -5.13%	8/29/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.59	▲ 3.51%	8/29/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1320.49	▲ 0.79%	8/29/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	998.5	▼ 0.93%	8/29/2017
МӨНГӨ	SIA	унци	17.565	▲ 0.21%	8/29/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	310.45	▲ 0.60%	8/29/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	75.03	▼ 0.08%	8/29/2017
WTI ТОС	CLA	баррель	46.65	▲ 0.17%	8/29/2017
БРЕНТ	COA	баррель	51.75	▲ -0.27%	8/29/2017
БЕНЗИН	XBA		171.14	▲ -0.05%	8/29/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.921	▼ -0.14%	8/29/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ 0.21%	8/29/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	97.75	▲ 0.26%	8/29/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	14.22	▲ -0.63%	8/29/2017
БУДАА	RRA	центнер	12.5	▲ -1.19%	8/29/2017
БУУДАЙ	WA	бушель	427	▲ -0.23%	8/29/2017
КАКАО	CCA	тонн	1992	▲ -0.25%	8/29/2017
КОФЕ	KCA	фунт	130.8	▲ -0.42%	8/29/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	457.11	▲ 1.18%	8/29/2017
ГОВЬ ХК	GOV	14990	▲ 1.28%	8/29/2017
МАХ ИМПЕКС ХК	MMX	2381	▼ -0.79%	8/29/2017
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	21000	▼ -1.41%	8/29/2017
СҮҮ ХК	SUU	165	◄ 0%	8/29/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	22000	▼ -0.45%	8/29/2017
БАГАНУУР ХК	BAN	2100	▲ 4.84%	8/29/2017
ХӨХ ГАН ХК	HGN	80	◄ 0%	8/29/2017
ЖЕНКО ТҮР БЮРА ХК	JTB	62	▲ 0.52%	8/29/2017
МОНГОЛ НЭХИЙ ХК	MNH	3200	▼ -0.06%	8/29/2017
РЕМИКОН ХК	RMC	41.72	▼ -0.12%	8/29/2017
ШИВЭЭ ГОВЬ ХК	SHG	2440	◄ 0%	8/29/2017
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	8000	▼ -0.81%	8/29/2017
УИД ХК	UID	509	▲ 2.29%	8/29/2017
СТАНДАРТ НООС ХК	ALI	400	◄ 0%	8/29/2017
ХИШИГ УУЛ ХК	HSX	1200	▼ -14.29%	8/29/2017
ТЭЭВЭР ДАРХАН ХК	TEE	14000	▲ 7.69%	8/29/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	6283.016	+17.37	▲ +0.28%	8/29/2017
DAX INDEX	DAX	11917.28	-206.19	▼ -1.7%	8/29/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15052.03	-3.96	▼ -0.03%	8/29/2017
S&P/ASX 200	AS51	5669.012	-40.88	▼ -0.72%	8/29/2017
S&P 500	INX	2444.24	+1.19	▲ +0.05%	8/29/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3365.226	+2.57	▲ +0.08%	8/29/2017
TOP 20	MSETOP	15610.73	+64.26	▲ +0.41%	8/29/2017
FTSE 100	UKX	7306.52	-94.94	▼ -1.28%	8/29/2017
HANG SENG	HSI	27765.01	-98.28	▼ -0.35%	8/29/2017
NIKKEI 225	NIKY	19362.55	-87.35	▼ -0.45%	8/29/2017

tdbpay

Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн төлбөрийн шинэ трэнд

Хурдан, шуурхай

Эрсдэлгүй, найдвартай

Ашиглахад хялбар

Бүрдүүлэх материал

- ✓ Иргэний үнэмлэх
- ✓ Үйл ажиллагаа эрхэлж буйг тодорхойлох баримт

+976 1900-1977 | www.tdbm.mn